



**Эрх зүйн боловсрол
академи**



**Өмгөөлөл судлалын
академи ТББ**

**АРИЛЖААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ
БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН БАЙР СУУРЬ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2020

Судалгааны захиалагч: “Ханнс-Зайделийн” сангийн “Эрх зүйн боловсрол” академи

Судалгааны гүйцэтгэгч: “Өмгөөлөл судлалын академи” ТББ

Судалгааны баг: **Тайлан боловсруулсан:**

Багийн удирдагч Б.Амарсанаа (Хууль зүйн ухааны доктор /LL.D/)

Багийн ахлагч З.Сүхбаатар (Бизнесийн удирдлагын доктор /Ph.D/), өмгөөлөгч

Тайлангийн боловсруулалтад оролцсон багийн гишүүд:

Багийн гишүүн Б.Мөнхбат (Хууль зүйн магистр), өмгөөлөгч

Багийн гишүүн П.Оюундэлгэр (Хууль зүйн магистр LL.M), өмгөөлөгч

Багийн гишүүн С.Батбаяр (Хууль зүйн магистр), судлаач

Багийн гишүүн Д.Аюуш (Социологич)

Багийн гишүүн Э.Эрдэнэцэцэг (Хууль зүйн магистр), өмгөөлөгч

Багийн гишүүн Б.Оюунтуул (Хууль зүйн магистр), өмгөөлөгч

Багийн гишүүн Э.Шүрэнцэцэг, хуульч

Багийн гишүүн Т.Эрхбилгүүн, хуульч

Мэдээлэл цуцлуулсан багийн гишүүд:

Багийн гишүүн Н.Болорчимэг (Хууль зүйн магистр), өмгөөлөгч

Багийн гишүүн Х.Жаргалсайхан, өмгөөлөгч

Багийн гишүүн Э.Эрдэнэцэцэг (Хууль зүйн магистр), өмгөөлөгч

Багийн гишүүн Б.Оюунтуул (Хууль зүйн магистр), өмгөөлөгч

Багийн гишүүн Э.Шүрэнцэцэг, хуульч

Багийн гишүүн Т.Эрхбилгүүн, хуульч

Багийн гишүүн Г.Сэлэнгээ, татварын мэргэшсэн зөвлөх

Багийн гишүүн Г.Мөнхцэцэг, хуульч

Багийн гишүүн М.Долгор, маркетингийн менежер

АГУУЛГА

ТАЛАРХАЛ	10
НЭГ. УДИРТГАЛ.....	11
1.1. Судалгааны зорилго	11
1.2. Судалгааны зорилт	12
1.3. Судалгааны асуудал.....	12
1.5. Сэдвийн судлагдсан байдал.....	13
1.6. Судалгааны арга.....	13
ХОЁР. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	18
2.1. Судалгааны ажлын төлөвлөгөө	18
2.2. Судлаачдын сургалт	20
2.3. Судалгааны багийн зохион байгуулалт	20
ГУРАВ. СУДАЛГААНД ОРОЛЦСОН БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ..	21
3.1. Санал асуулгын судалгаанд оролцогчдын мэдээлэл	21
3.2. Ярилцлагын судалгаанд оролцогчдын мэдээлэл	25
ДӨРӨВ. БИЗНЕС ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХЭЛЦЛИЙН БАТАЛГААТ, ТҮРГЭН ШУУРХАЙ БАЙДАЛ, АШГИЙН ТӨЛӨӨХ ЗОРИЛГЫГ ХАНГАХ АСУУДАЛ	28
4.1. Хувиараа бизнес эрхлэгчийн арилжааны нэр	28
4.2. Үл өрсөлдөх үүргийг хуульчлах асуудал	29
4.3. Төлөөлөх бүрэн эрхийн асуудал	30
4.4. Хөөн хэлэлцэх хугацаа.....	37
4.5. Хэлцлийн хэлбэрийн шаардлагын асуудал.....	39
4.6. Хэлцлийн зардлын хуваарилалт	42
4.7. Хуульд заасан хүүгийн талаар.....	43
4.8. Бизнесийн гэрээ, хэлцэлд холбогдох эрх зүйн зохицуулалтын зарим асуудал	45
4.9. Бизнесийн гэрээг байгуулсанд тооцохтой холбоотой асуудал.....	46
4.10. Тулгамдаж байгаа асуудлаа бизнес эрхлэгчид эрэмбэлсэн байдал, агуулга	49
ТАВ. БИЗНЕСИЙН ОРЧИН НӨХЦӨЛ, АРИЛЖААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА	56
5.1. Гэрээ, хэлцлийн талууд бие биедээ итгэх итгэлийн төвшин.....	56
5.2. Гэрээний тохиролцоог эрх зүй хамгаалж чадаж байгаа эсэх, шалтгаан.....	58
5.3. Бизнесийн харилцаанд тохирсон эрх зүйн орчинг бий болгох нь	60
5.4. Бизнесийн маргаан шийдвэрлэх процессын эрх зүйн асуудал	63

5.5. Судалгааны хүрээнд хөндөгдсөн бусад асуудал	64
ЗУРГАА. СУДАЛГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ.....	70
6.1. Одоогийн эрх зүйн орчинд тулгамдаж буй асуудал.....	71
6.2. Шинээр зохицуулах шаардлагатай асуудал.....	74
6.3. Арилжааны харилцааг тусгайлан зохицуулах хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага	76
ДОЛОО. ДҮГНЭЛТ, САНАЛ.....	78
7.1. Дүгнэлт	78
7.2. Санал.....	79
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	79

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Санал асуулгын түүврийн хэмжээг тооцох нь	16
Хүснэгт 2. Судалгааны ажлын төлөвлөгөө	18
Хүснэгт 3. Санал асуулгын судалгаанд оролцогчдын хүн ам зүйн болон байгууллагын мэдээлэл	21
Хүснэгт 4. Ярилцлагын судалгаанд оролцогчдын хүн ам зүйн болон байгууллагын мэдээлэл	26
Хүснэгт 5. Хуулийн этгээдийн бүх гэрээ, хэлцэл нэг хүн буюу гүйцэтгэх захирлаас хамааралтай байх нь бизнесийн үйл ажиллагааны түргэн шуурхай байдалд нөлөөлөх байдал (бизнес эрхэлж буй хэлбэрээр).....	35
Хүснэгт 6. Хэлцлийн зардлын хуваарилалт	43
Хүснэгт 7. Хуульд заасан хүүтэй холбоотой зохицуулалтыг дэмжих эсэх	44
Хүснэгт 8. Бизнес эрхлэгчдийн хувьд тулгамдаж байгаа асуудлыг эрэмбэлсэн байдал.....	49

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Санал асуулгын судалгаанд оролцогчдын үйл ажиллагааны чиглэл	22
График 2. Санал асуулгын судалгаанд оролцогчдын бизнесийн үйл ажиллагаа явуулсан туршлага (жилээр).....	23
График 3. Санал асуулгын судалгаанд оролцогчдын эрхэлдэг ажил, албан тушаал (давхардсан тоогоор) ба бизнес эрхэлсэн туршлага (жилээр).....	24
График 4. Санал асуулгын судалгаанд оролцогчдын мэргэжлийн болон бизнесийн байгууллагын гишүүнчлэл.....	24
График 5. Санал асуулгын судалгаанд оролцогчдын нэг сарын хугацаанд амаар болон бичгээр хийдэг гэрээ, хэлцлийн дундаж тоо (үйл ажиллагааны салбараар).....	25
График 6. Ярилцлагын судалгаанд оролцогчдын үйл ажиллагааны салбарын ангилал	27
График 7. Хувиараа бизнес эрхлэгч иргэн нь бизнес эрхлэхдээ хэрэглэдэг өөрийн хамгаалагдсан нэртэй байх хэрэгцээ, шаардлага	28
График 8. Үл өрсөлдөх үүргийг хуульчлах шаардлага	30
График 9. Төлөөлөгч, итгэмжлэл бүхий этгээдтэй холбогдох одоогийн эрх зүйн зохицуулалт хангалттай эсэх	31
График 11. Хуулийн этгээдийн бүх гэрээ, хэлцэл нэг хүн буюу гүйцэтгэх захирлаас хамааралтай байх нь бизнесийн үйл ажиллагааны түргэн шуурхай байдалд нөлөөлөх байдал.....	33
График 12. Хуулийн этгээдийн бүх гэрээ, хэлцэл нэг хүн буюу гүйцэтгэх захирлаас хамааралтай байх нь бизнесийн үйл ажиллагааны түргэн шуурхай байдалд нөлөөлөх байдал.....	34
График 13. Бизнес эрхлэгч хоорондын гэрээний хөөн хэлэлцэх хугацаан дээр нэмж гомдлын шаардлага гаргах хугацааг тоолдог нь бизнесийн харилцаанд оновчтой эсэх	37
График 14. Бизнес эрхлэгч хоорондын гэрээний хөөн хэлэлцэх хугацаан дээр нэмж гомдлын шаардлага гаргах хугацааг тоолдог нь бизнесийн харилцаанд оновчтой эсэх (ажил, албан тушаалаар)	38
График 15. Олон жилийн турш харилцсан хамтрагчтайгаа аман хэлбэрээр гэрээ байгуулахыг зөвшөөрсөн эрх зүйн зохицуулалтыг дэмжих эсэх.....	40
График 16. Хуульд заасан хүүтэй холбоотой зохицуулалтыг дэмжих эсэх (ажил, албан тушаалаар).....	45
График 17. Бизнес эрхлэгч хоорондын гэрээ, хэлцэлд холбогдох эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай асуудал	46
График 18. Бизнесийн гэрээ, хэлцлийг байгуулсанд тооцохтой холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоход анхаарах асуудал.....	47
График 19. Монгол Улс дахь бизнесийн нөхцөл байдал, гэрээ, хэлцлийн талууд бие биедээ итгэх итгэл.....	56
График 20. Монгол Улс дахь бизнесийн нөхцөл байдал, гэрээ, хэлцлийн талууд бие биедээ итгэх итгэл (үйл ажиллагааны салбараар).....	57
График 21. Монголын бизнесийн практикт тохиролцсондоо хүрэхгүй байх эрсдэл	57

График 22. Гэрээ, хэлцлээр хийсэн тохиролцоог хамгаалах эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх, сайжруулах шаардлага	58
График 23. Бизнесийн болон гэрээ, хэлцлийн харилцаанд өөрийн байр суурь, эрсдэлээ хуулийн хүрээнд хангалттай хэмжээнд хамгаалж чадаж байгаа байдал	59
График 24. Хуулиар бизнес эрхлэгч хоорондын гэрээний харилцааг хангалттай зохицуулсан эсэх, түүний шалтгаан	60
График 25. Бизнесийн харилцааг зохицуулсан эрх зүйн орчны хувьд дутмаг буюу сайжруулах шаардлагатай байгаа асуудал.....	60
График 26. Бизнес эрхлэгч хоорондын харилцааг зохицуулсан хууль (Commercial Code буюу Арилжааны хууль) гаргах хэрэгцээ, шаардлага	61
График 27. Бизнес эрхлэгч хоорондын харилцааг зохицуулсан хууль (Commercial Code буюу Арилжааны хууль) гаргах хэрэгцээ, шаардлага (ажил, албан тушаалаар)	62
График 28. Бизнес эрхлэгчдийн маргааныг шийдвэрлэх одоогийн тогтолцоо, шүүхийн процесс шаардлага хангаж байгаа эсэх.....	63

ЯРИЛЦЛАГЫН ЖАГСААЛТ

Шигтгээ 1. "А" ХК-ийн хуулийн албаны даргатай хийсэн ярилцлагаас	40
Шигтгээ 2. "М" ХХК-ийн захиралтай хийсэн ярилцлагаас.....	41
Шигтгээ 3. "KPMG Mongolia Audit" ХХК-ийн татварын ахлах мэргэжилтэн, хуульчтай хийсэн ярилцлагаас.....	41
Шигтгээ 4. "МБМБ" ТББ-ын захиралтай хийсэн ярилцлагаас.....	47
Шигтгээ 5. "Зайнаас гэрээ байгуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал: Банкны жишээн дээр" нийтлэлээс	48
Шигтгээ 6. "Д И" ХХК-ийн захиралтай хийсэн ярилцлагаас	51
Шигтгээ 7. "ЭПСЭО" ХХК-ийн хуулийн зөвлөхтэй хийсэн ярилцлагаас	59
Шигтгээ 8. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг компанийн захиралтай хийсэн ярилцлагаас.....	64
Шигтгээ 9. Хүлэмжийн аж ахуй, хүнсний ногоо тариалалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг "М" ХХК-ийн захиралтай хийсэн ярилцлагаас.....	65
Шигтгээ 10. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг "ДЧ" ХХК-ийн гүйцэтгэх захиралтай хийсэн ярилцлагаас	65
Шигтгээ 11. Барилгын үйл ажиллагаа эрхэлдэг компанийн захиралтай хийсэн ярилцлагаас	66
Шигтгээ 12. Төсөл хэрэгжүүлдэг компанийн захиралтай хийсэн ярилцлагаас.....	67

ТАЛАРХАЛ

Ханнс зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, түүний тэргүүн, доктор, профессор Ц.Сарантуяа, Эрх зүйн боловсрол академийн гүйцэтгэх захирал А.Энхтуяа, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг болон санал асуулгад оролцсон бизнес эрхлэгчиддээ судлаачдын зүгээс гүнээ талархал илэрийлж байна.

ТАЙЛБАР

Энэхүү судалгаанд судалгааны үндсэн хоёр арга болох санал асуулгын болон ярилцлагын аргыг хэрэглэсэн бөгөөд ярилцлагын судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн зүгээс өгсөн хариултыг статистик байдлаар дурдаагүй болно. Өөрөөр хэлбэл, тодорхой тоон мэдээлэлд үндэслэн дурдсан судалгааны мэдээлэл, дүгнэлтүүд нь зөвхөн санал асуулгын судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн хариултад үндэслэсэн болно. Иймд ярилцлагын судалгаа хэмээн тусгайлан дурдаагүй бол санал асуулгын судалгааг нэрлэн заасан гэж ойлгох бөгөөд ярилцлага болон санал асуулгын судалгааны аль алинд үндэслэсэн агуулгыг илэрхийлэхдээ энэ тухай тухайлан дурдсан болно.

НЭГ. УДИРТГАЛ

1.1. Судалгааны зорилго

Эх газрын эрх зүйн бүлд харьяалагдах¹ зах зээлийн эдийн засаг бүхий улсууд иргэд хоорондын эдийн засгийн үйл ажиллагаа болон бизнес эрхлэгч² (энэхүү судалгаанд оролцогчид “арилжаа эрхлэгч” хэмээх томъёолол оновчтой гэж үзэж байгаа хэдий ч одоогоор энэ нэр томъёог нийтээр хэрэглэж заншаагүй, зарим тохиолдолд ойлгомжгүй байдал үүсэхээс сэргийлэн энэхүү тайланд “бизнес эрхлэгч” гэх томъёоллыг хэрэглэв) хоорондын эдийн засгийн үйл ажиллагааг ялгамжтайгаар зохицуулж ирсэн түүхэн уламжлалтай байдаг. Харин Монгол Улсын хувьд иргэд хоорондын болон бизнес эрхлэгч хоорондын харилцааг Иргэний хуулиар хамтатган, ялгамжтай бус байдлаар нэгтгэн зохицуулж байна. Өөрөөр хэлбэл, Иргэний хуульд бизнес эрхлэгчийн үйл ажиллагаа, тэдгээрийн хийдэг хэлцэл болон хэлцлийн бус харилцаанд бизнес эрхлэгчид нэмэгдэл үүрэг хүлээлгэх зэргээр бизнесийн үйл ажиллагаанд хамаарах харилцааг иргэд хоорондын харилцаанаас ялгамжтайгаар авч үзсэн зохицуулалт бага хэмжээгээр агуулагдах хэдий ч бизнес эрхлэгч гэж хэн болох нь хувийн эрх зүйн суурь хуульд тусгагдаагүй, хангалттай тодорхой зохицуулаагүйгээс аж ахуй эрхлэх явцад үүссэн асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэх, хэлцлийн баталгаат байдал, ашгийн төлөөх шинжийг хангах боломжгүй байдал үүсч байдаг.

Энэ талаар 2019 онд МУИС-ийн ХЗС-ийн судлаачдын хийсэн “Арилжааны хуулийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны тайлан”-гаас үзэхэд одоогийн Иргэний хуулийн зохицуулалт нь бизнес эрхлэгчдийн хоорондын арилжааны шинжтэй гэрээ хэлцлийн харилцааг хангалттай, бүрэн дүүрэн зохицуулж чадахгүй байгааг Иргэний хуулийн холбогдох зүйл заалтууд, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргаар илрүүлсэн байна. Гэсэн хэдий ч тус судалгаа нь Иргэний хууль болон түүнийг хэрэглэж маргаан шийдвэрлэж буй шүүхийн шийдвэрийг Арилжааны эрх зүй дэх онол, зарчмуудтай харьцуулах замаар хийсэн байдаг бөгөөд бизнес эрхлэгчийн санал бодлыг тусгасан эмпирик түвшний судалгаа төдийлөн хийгээгүй байна.

Иймд энэхүү судалгаагаар компанийн хувьцаа эзэмшигч, нөхөрлөлийн гишүүн, хувиараа бизнес эрхлэгч зэрэг өмчийн эзэн, компанийн төлөөлөн удирдах

¹ Эх газрын эрх зүйн уламжлалтай улсууд, жишгийн эрх зүйн уламжлалтай улсуудад ялгалгүй бизнес эрхлэгчийг тусгайлан зохицуулсан, тэдгээрийн онцлогийг харгалзсан эрх зүйн орчин үйлчилж байдаг. Жишээлбэл, АНУ-ын ихэнх муж улсад батлагдсан Uniform Commercial Code-д ийнхүү ялгамжтай зохицуулалт хийсэн байдаг.

² Энэхүү судалгаанд бизнес эрхлэгч гэх нэр томъёог ашигласан бөгөөд уг нэр томъёонд бүх төрлийн бизнес эрхлэгч хувь этгээд, хуулийн этгээд, аж ахуй эрхлэгч, арилжаа эрхлэгч зэргийг хамааруулсан болно.

зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага (гүйцэтгэх захирал, санхүү, хуулийн асуудал эрхэлсэн албан тушаалтан), салбар, нэгж хариуцсан захирал г.м. албан тушаалтан, худалдагч зэрэг бусад бизнес эрхлэгч, эсхүл хэрэглэгчтэй шууд харилцах үүрэг бүхий ажилтан зэрэг бизнес эрхэлж буй субъектүүдээс санал асуулга авах, ганцаарчилсан уулзалт, ярилцлага хийх зэргээр бизнес эрхлэгчдийн бизнесээ эрхлэхэд одоогийн эрх зүйн орчин хангалттай зохицуулж чадаж байгаа эсэх, ямар асуудал тулгарч байгаа, эсхүл Иргэний хуулиас тусдаа бизнес эрхлэгчдийн бизнесийн харилцааг тусгайлан зохицуулсан Арилжааны хууль тогтоомж хэрэгтэй эсэхийг судлах зорилготой болно. Энэ зорилгын хүрээнд төрийн өмчит үйлдвэрийн газар, хоршоо, төрийн бус байгууллага (уг судалгаанд төрийн бус байгууллагыг хамруулахгүй байсан хэдий ч бизнес эрхлэгчдийн санхүүгийн эрсдлийн ашиг сонирхлыг хамгаалахаар нийгэмд үйлчилдэг, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг) зэрэг хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтнаас мөн адил судалгаа авсан болно.

1.2. Судалгааны зорилт

Энэхүү судалгааны хүрээнд бизнес эрхлэгчидтэй уулзалт, ярилцлага хийх, санал асуулга авах замаар одоогийн эрх зүйн орчны хүрээнд бизнесийн эрх зүйн харилцааг хангалттай хэмжээнд зохицуулж чадаж байгаа эсэх, эсхүл бие даасан Арилжааны хууль тогтоомж шаардлагатай эсэхийг судлах зорилт тавьсан болно.

1.3. Судалгааны асуудал

Судалгааны хүрээнд шийдвэрлэх дараах асуудлууд байна. Үүнд:

- Бизнесийн орчин дахь бизнес эрхлэгчдийн гэрээ, хэлцэлд итгэх итгэлийн төвшин;
- Одоогийн эрх зүйн зохицуулалт нь бизнес эрхлэгчдийн өмнө тулгарч байгаа асуудлыг зохицуулж чадаж байгаа эсэх;
- Одоогийн эрх зүйн зохицуулалтын төвшинд зохицуулалтгүй байгаа бизнесийн харилцааг шинээр зохицуулах шаардлагатай байгаа эсэх;
- Иргэд хоорондын болон бизнес эрхлэгчийн харилцааг ялгамжтайгаар зохицуулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэх.

1.4. Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгааг дараах хүрээнд хийж гүйцэтгэсэн болно. Бизнес эрхлэгчдийн төлөөлөл болохуйц нийт 604 бизнес эрхлэгчээс 32 асуулт бүхий санал асуулга (*Хавсралт 1*) авч, тэдгээрт анализ, дүгнэлт хийв.

Мөн гол мэдээлэгч (*key informant*) буюу бизнесийн тухайн салбарын талаар өргөн мэдлэгтэй 73 бизнес эрхлэгч болон түүний бизнесийг удирдан явуулдаг албан тушаалтантай ганцаарчилсан ярилцлага хийсэн болно. Тодруулбал:

- Компани, нөхөрлөл, хувиараа бизнес эрхлэгч (1-9 ажилтантай)-ээс 29 ярилцлага;
- Компани, нөхөрлөл, хувиараа бизнес эрхлэгч (10-49 ажилтантай)-ээс 27 ярилцлага;
- Компани, нөхөрлөл, хувиараа бизнес эрхлэгч (50-аас дээш ажилтантай)-ээс 16 ярилцлага;
- Төрийн бус байгууллага (1-9 ажилтантай)-аас 1 ярилцлага.

1.5. Сэдвийн судлагдсан байдал

2019 онд ХБНГУ-ын Ханнс Зайделийн сангийн дэмжлэгтэйгээр “Арилжаа (худалдаа)-ны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа”³-г хийж гүйцэтгэсэн байна. Харин бизнес эрхлэгчдээс Арилжааны хууль, хөндөгдөх эрх зүйн зохицуулалтын тухайлсан зарим асуудлын хүлээн зөвшөөрөгдөх байдлын талаар иж бүрэн санал асуулга авч байгаагүй, ярилцлагын судалгаа хийгдээгүй гэж үзсэн болно.

1.6. Судалгааны арга

Уг судалгааны ажлын хүрээнд нийгмийн судалгаанд хэрэглэгддэг олон улсын нийтлэг онол, арга зүй, тэргүүн туршлага, шинжлэх ухааны аргачлалд тулгуурлан “Санал асуулгын судалгаа”-г гүйцэтгэх арга зүйн хүрээнд боловсрууллаа. Арга зүйг боловсруулахдаа дараах зарчмыг баримталсан. Үүнд:

- Захиалагчийн зүгээс судалгааны ажлын даалгаварт дурдсан ажилбар бүрийг бүрэн дэлгэрэнгүй түвшинд хамарсан байх;
- Олон улсын болон үндэсний түвшинд хэрэглэгдэж буй нийтлэг арга зүй, тэргүүн туршлагад үндэслэсэн байх, судалгааны үе шат тус бүрд ёс зүйн болон мэргэжлийн стандартуудыг дагаж мөрдөх;
- Шинжлэх ухааны болон практикийн үндэслэл, нотолгоотой, ач холбогдолтой арга зүйг сонгосон байх;
- Аргачлал, арга зүй зохион байгуулалт нь эдийн засгийн болон ажлын эцсийн үр дүнгийн хувьд үр ашигтай байх зэрэг болно.

Бүдүүвч 1. Судалгааны ажлын арга зүйн зураглал

³ <http://legaldata.mn/b/519>



Судалгааны бэлтгэл үе шат

- Судалгааны хөтөлбөр боловруулах
- Судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулах
- Тайлангийн бүтэц гаргах
- Талбарт судалгаа хийх зохион байгуулалтыг хангах, судалгааны талбарт гарах
- Баримт бичгийн судалгаа хийх



Мэдээлэл цуглуулалтын үе шат

- Судалгаанд оролцогчдын байршил, мэдээлэлтэй танилцах
- Ганцаарчилсан ярилцлага (IDI)
- Асуулгын буюу тоон судалгаа (SURVEY)
- Программд өгөгдлийг оруулах
- Өгөгдлийг боловсруулах
- Үр дүнг тооцох



Тайлагнах үе шат

- Тоон судалгаанд дүн шинжилгээ хийх
- Чанарын судалгааг хэв загвар, бүлэглэл хийх, шигтээ, кейс
- Судалгааны дэлгэрэнгүй тайлан бэлтгэх
- Хавсралт материалууд
- Мэдээллийн дата бааз
- Эцсийн тайлан

Судалгааны мэдээлэл цуглуулах арга

Судалгааны мэдээлэл цуглуулах үндсэн арга нь санал асуулгын болон ярилцлагын арга бөгөөд үүний зэрэгцээ боломжит бүхий л эх сурвалжуудаас мэдээлэл цуглуулах зорилт тавьсан. Ингэснээр олон талын байр суурь, санал бодол, мэдээллүүдийг нэгтгэн дүгнэх бололцоотой болох ба судалгааны үр дүн илүү бодитой гарах болно.

Судалгаанд тоон ба чанарын судалгааны аргуудыг хэрэглэсэн. Ямар эх сурвалжаас ямар төрлийн мэдээлэл авахаас шалтгаалан судалгааны мэдээлэл цуглуулах тохирох аргыг хэрэглэсэн болно. Анхдагч мэдээлэл цуглуулах дараах аргуудыг ашиглав. Үүнд:

- Санал асуулгын арга (анкет)
- Ярилцлагын арга (ганцаарчилсан)

Санал асуулгын арга (анкет): Тус арга нь олон нийтийн санаа бодол, хүсэл эрмэлзэл, хандлага, үнэлгээг тодорхойлоход хамгийн тохиромжтой мэдээлэл цуглуулах үндсэн арга билээ. Санал асуулгыг PAPI буюу нүүр тулсан (Paper and

Pen Interviewing) хэлбэрээр авсан бөгөөд судалгааны явцад илэрсэн онцлог тохиолдол (case) бүхий, үнэ цэнэтэй мэдээлэл өгөх зарим гол мэдээлэгч (key informant)-ээс ганцаарчилсанавсан болно.

Ганцаарчилсан ярилцлагын арга: Тус арга нь санал асуулгын аргаар авсан мэдээллийн учир шалтгаан, мөн чанар, дотоод зүй тогтлыг илэрхийлэн гаргахад ихээхэн үр дүнтэй байдаг. Тиймээс энэхүү судалгаанд ганцаарчилсан ярилцлагаар санал асуулгын судалгааны мэдээллийг гүнзгийрүүлэн шалгах, учир шалтгааныг нь тодорхойлохоор мэдээллүүдийг цуглуулсан болно. Дараах субъектүүдээс ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан болно. Үүнд:

- Компанийн хувьцаа эзэмшигч, нөхөрлөл, хоршооны гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад албан тушаалтан;
- Хувиараа бизнес эрхлэгч;
- Аж ахуйн нэгжийн хуулийн зөвлөх, өмгөөлөгч, бизнес эрхлэгчийг төлөөлөн бизнесийн үйл ажиллагааг биечлэн явуулж байгаа борлуулагч, худалдагч болон бусад мэдээлэл, мэдлэгтэй хүмүүс.

Санал асуулгын судалгааны түүвэр

Бизнес эрхлэгчдэд тулгарч байгаа нийтлэг асуудал, бизнесийн гэрээ, хэлцэлд холбогдох эрх зүйн зохицуулалтыг сайжруулах хэрэгцээ, шаардлага, тулгамдаж буй асуудлыг тодруулан, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрх зүйн хэм хэмжээний зохицуулалтыг өөрчлөн сайжруулах шаардлага бий эсэхийг тодруулах зорилгоор 32 асуулт бүхий санал асуулгыг бэлтгэсэн.

Тус санал асуулгад Улаанбаатар хот болон орон нутгийн 604 бизнес эрхлэгчдийг хамруулсан бөгөөд судалгааны санал асуулгын түүврийг тооцохдоо Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоог эх олонлогоо (N) болгож түүвэрлэн тооцож гаргасан болно. Аргачлалын дагуу 99.7 хувийн баталгааны түвшинтэй, итгэх интервал нь ± 5 хувь байхаар тооцож үзвэл хамгийн ихдээ 580 бизнес эрхлэгчдийг хамруулан тооцоолоход хангалттай болно.

Судалгааны түүврийн нэгж нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, компани, хувиараа бизнес эрхлэгчид байв.

Хүснэгт 1. Санал асуулгын түүврийн хэмжээг тооцох нь

Үзүүлэлт	Утга		
Улаанбаатар хотод байршилтай аж ахуй нэгж байгууллагууд=N	58993 ⁴		
Эндээс судалгааны шаардлагтай, төлөөлж чадах түүврийн хэмжээ =n	580≤		
	ААН, ХХК 3.4% (50-аас дээш хүнтэй)	ААН, ХХК 12.5% (10-49 хүнтэй)	Хувиараа бизнес эрхлэгчид 84.1% (1-9 хүнтэй)
	50	80	450
Итгэх түвшин			99.7%
Итгэх интервал			±5%

Судалгааны явцад цуглуулсан мэдээллийг Excel програмд оруулж нэгтгээд, логик алдааг магадлан, мэдээллийн санг цэвэрлэсний эцэст тоон мэдээллийн шинжилгээний SPSS (Statistical Programm for Social Science) 20.0 програмыг ашиглан боловсруулалт хийсэн болно.

Чанарын судалгааны мэдээллийг энгийн нэгтгэлийн аргаар үүсгэн категорчилж, судалгааны үр дүнг боловсруулж, нэгтгэсэн болно.

Бизнес эрхлэгчдэд тулгарч байгаа нийтлэг асуудал, гэрээ, хэлцэлтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг сайжруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тодруулах, одоо байгаа зохицуулалтыг өөрчлөн сайжруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тодруулах зорилготой санал асуулгын судалгааг нийт 28 талбар, 604 бизнес эрхлэгчдээс авсан болно.

Ярилцлагын судалгааны түүвэр

Дэлхий нийтийг хамарсан COVID-19 цар тахал олон улсад тархаж, Монгол Улсад хорио цээрийн дэглэм тогтоосны улмаас ярилцлагын судалгааг биечлэн уулзалт, ярилцлага хийх аргаар явуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн хэдий ч ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулахдаа тухайн бизнесийн салбарын гол мэдээлэгч (*key informant*) буюу өргөн мэдлэг бүхий үүсгэн байгуулагч, хувьцаа

⁴ <http://www.1212.mn>, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо, 2019 оны 2-р сарын байдлаар

эзэмшигч, гишүүн, гүйцэтгэх удирдлага, удирдах албан тушаалтан, менежер, санхүү хариуцсан ажилтан (нягтлан бодогч), хуулийн зөвлөхүүдтэй утсаар, цахим шуудан болон олон нийтийн цахим сүлжээ (фэйсбүүк/Facebook/, вайбер /viber/, телеграм/telegram/, вичат /wechat/, зүүм/zoom/ гэх мэт)-ээр дамжуулан харилцах аргыг ашигласан болно.

Судалгааны ажлын даалгаварт Улаанбаатар хот болон шаардлагатай тохиолдолд бусад төв суурин газруудын бизнес эрхлэгчдийг ажилтан (ажиллах хүч)-ы тоо болон хуулийн этгээдийн хэлбэрийг харгалзан хамруулсан болно. Тиймээс Улаанбаатар хотод байршилтай нийт 73 бизнес эрхлэгчдийг ажилтан (ажиллах хүч)-ы тоо болон хуулийн этгээдийн хэлбэрийг харгалзахгүй ярилцлагын судалгаанд хамруулсан бөгөөд үүнээс 44.4 хувийг биечлэн уулзаж, 20.9 хувийг утсаар харилцаж, 34.7 хувийг цахим шуудан ба олон нийтийн цахим суваг (фэйсбүүк/Facebook/, вайбер /viber/, телеграм/telegram/, вичат /we chat/, зүүм/zoom/ гэх мэт) ашиглан ярилцаж мэдээллийг цуглуулсан болно.

ХОЁР. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Судалгааны ажлын төлөвлөгөө

Судалгааны ажлыг 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр дараах ажлын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

Хүснэгт 2. Судалгааны ажлын төлөвлөгөө

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа		Ажиллах хугацаа														
	Нийт 180 хоног		1 сар			2 сар			3 сар			4 сар	5 сар	6 сар		
	СУДАЛГААНЫ БЭЛТГЭЛ ҮЕ ШАТ															
1.	Багийн гишүүд, захиалагч талтай уулзалт хийх															
2.	Судалгааны хөтөлбөрийг эцэслэн боловсруулах															
3.	Сургалт явуулах: тоологчид болон операторууд, судалгааны багийн гишүүдэд зориулсан сургалт															
4.	Талбарт судалгаа хийх зохион байгуулалтын бэлтгэлийг хангах, судалгааны талбарт гарах															
	СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮЕ ШАТ: МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, ӨГӨГДӨЛ ОРУУЛАХ															
1.	Судалгаа авах байгууллагуудын байршил, мэдээлэлтэй танилцах															
2.	Тухайн талбараас түүврийг нарийвчлан тодорхойлох															
3.	Судалгааны багууд талбараас мэдээлэл цуглуулах (анкет, ярилцлага)															
4.	Судалгааны мэдээлэл цуглуулах ажлын явцын тайланг гаргах															

[illegible]

2.2. Судлаачдын сургалт

Судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу судалгааны баг дараах сургалт, уулзалтыг хийсэн болно. Үүнд:

№	Сургалтын агуулга	Хугацаа	Оролцогчид
1.	Судалгааны багийн удирдагч “Арилжаа (худалдаа)-ны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан”-аас танилцуулж, Арилжаа /Худалдаа/-ны эрх зүй болон Иргэний эрх зүйн зарчмын ялгааг судлахад Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулсан нийтлэг зарчмуудын талаарх болон санал асуулгын төслийг танилцуулсан.	2019 оны 12-р сарын 31-ний өдөр	Судалгааны багийн гишүүд
2.	Санал солилцох сургалт	2020 оны 01-р сарын 06-ны өдөр	Захиалагч талаас доктор, профессор төслийн удирдагч Ц.Сарантуяа, Эрх зүйн боловсролын академийн гүйцэтгэх захирал А.Энхтуяа, судалгааны багийн гишүүд
3.	Судалгааг хэрхэн авах талаар арга зүйн зөвлөгөө өгч, анхаарах асуудлын талаар сургалт хийсэн.	2020 оны 1-р сарын 15-ны өдөр	Судалгааны багийн гишүүд
4.	Судалгаа авах байгууллагуудын байршил, мэдээллийг судлаачдад танилцуулж, судалгаа авах байгууллагын байршлыг судлаачдад хуваарилсан.	2020 оны 1-р сарын 20-ны өдөр	Судалгааны багийн гишүүд
5	Судалгааны үр дүнг нэгтгэх, хянахтай холбоотой уулзалт	2020 оны 2-р сарын 19-ний өдөр	Судалгааны багийн гишүүд

2.3. Судалгааны багийн зохион байгуулалт

Судалгааны багийн ахлагч ажлын төлөвлөгөөний дагуу судлаачдыг багийн зохион байгуулалтад оруулж, ажил үүргийг хуваарилан, ажлын чиглэлийг нарийвчлан танилцуулж, тэдний ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэн ажилласан.

Тус судалгааг гүйцэтгэхэд багийн ахлагч 1, багийн гишүүн буюу социологич 1, судалгааны мэдээлэл цуглуулж, санал асуулгын тоон мэдээг нэгтгэн дүгнэх 10, нийт 12 судлаачдын бүрэлдэхүүнтэйгээр ажиллав.

ГУРАВ. СУДАЛГААНД ОРОЛЦСОН БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

3.1. Санал асуулгын судалгаанд оролцогчдын мэдээлэл

Энэхүү судалгаанд 604 бизнес эрхлэгчид буюу тэдний төлөөлөгчид оролцсон бөгөөд тэдний 32.6 хувь нь эрэгтэй, 67.4 хувь эмэгтэй байна. Насны бүтцийн хувьд 1 хувь нь 18 хүртэл, 44.4 хувь нь 19-35 хүртэл, 32.8 хувь нь 36-45 хүртэл, 21.8 хувь нь 46-аас дээш настай байна.

Хүснэгт 3. Санал асуулгын судалгаанд оролцогчдын хүн ам зүйн болон байгууллагын мэдээлэл

№	Утга	Тоололт	Хувь
Таны нас			
1	18 хүртэл настай	6	1.0
2	19-35 настай	267	44.4
3	36-45 настай	197	32.8
4	46-аас дээш настай	134	21.8
Таны хүйс			
1	Эрэгтэй	198	32.6
2	Эмэгтэй	406	67.4
Бизнес эрхэлдэг хэлбэр			
1	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	140	23.6
2	Хувьцаат компани	29	4.9
3	Төрийн өмчит үйлдвэрийн газар	8	1.4
4	Хувиараа бизнес эрхлэгч	356	60.1
5	Хоршоо	3	.5
6	Нөхөрлөл	21	3.5
7	Бусад	47	5.9
Танай байгууллагын ажилтны тоо			
1	1-4 хүнтэй	380	62.4
2	5-9 хүнтэй	81	13.6
3	10-49 хүнтэй	81	13.6
4	50-199 хүнтэй	31	5.2
5	200-аас дээш хүнтэй	31	5.2
Эрхэлдэг ажил, албан тушаал (давхардсан тоогоор)			
1	Компанийн хувьцаа эзэмшигч, нөхөрлөлийн гишүүн	43	7.3
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга эсхүл гишүүн	6	1.0
3	Гүйцэтгэх удирдлага	64	10.8

4	Санхүү хариуцсан албан тушаалтан	43	7.3
5	Хуульч, хуулийн асуудал хариуцсан албан тушаалтан	24	4.1
6	Салбарын захирал, нэгж хариуцсан албан тушаалтан	53	9.0
7	Худалдагч, борлуулалт хариуцсан ажилтан	306	51.8
8	Бусад (гадаад харилцааны ажилтан, мэргэжилтэн, ахлах менежер, түрээслэгч гэх мэт)	99	16.8

Бизнесийн үйл ажиллагааны хэлбэрийн хувьд 23.6 хувь нь ХХК, 4.9 хувь нь ХК, 1.4 хувь нь ТӨҮГ, 60.1 хувь нь хувиараа бизнес эрхлэгч, 0.5 хувь нь хоршоо, 3.5 хувь нь нөхөрлөл, 5.9 хувь нь бусад төрлийн бизнес эрхлэгч, байгууллага байна. Ажилтны тооны хувьд 62.4 хувь нь 1-4 хүнтэй, 13.6 хувь нь 5-9 хүнтэй, 13.6 хувь нь 10-49 хүнтэй, 5.2 хувь нь 50-199 хүнтэй, 5.2 хувь нь 200-аас дээш хүнтэй байна. Харин судалгаанд оролцогчдыг ажил, албан тушаалаар авч үзвэл, 7.3 хувь нь компанийн хувьцаа эзэмшигч, нөхөрлөлийн гишүүн, 1 хувь нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, эсхүл гишүүн, 10.8 хувь нь гүйцэтгэх удирдлага, 7.3 хувь нь санхүү хариуцсан албан тушаалтан, 4.1 хувь нь хуульч, хуулийн асуудал хариуцсан албан тушаалтан, 9 хувь нь салбарын захирал, нэгж хариуцсан албан тушаалтан, 51.8 хувь нь худалдаа борлуулалт хариуцсан ажилтан, 16.8 хувь нь гадаад харилцааны ажилтан, мэргэжилтэн, ахлах менежер, түрээслэгч зэрэг бусад ажилтан байна. Эндээс үзвэл бизнес эрхлэгчдийн бүхий л төлөөллийг оролцуулснаар нэг талын бус олон талын үзэл бодол, хандлага, харилцааг харуулж байгаа болно.


График 1. Санал асуулгын судалгаанд оролцогчдын үйл ажиллагааны чиглэл



Судалгаанд оролцогчдын 56 хувь нь жижиглэн болон бөөний худалдаа, 13.6 хувь нь дээрхээс бусад төрлийн үйлчилгээ, 6.7 хувь нь үйлдвэрлэл, 4.6 хувь нь

банк, санхүү, даатгал, 3.9 хувь нь үл хөдлөх хөрөнгийн зуучлал, худалдаа, 3.6 хувь нь барилга, зам, дэд бүтцийн салбар, 3.1 хувь нь аялал жуулчлал, 2.9 хувь нь хуулийн зөвлөгөө, өмгөөлөл, 2.6 хувь нь уул уурхай, 2.0 хувь нь тээвэр, зууч, ложистик, 1.5 хувь нь мал аж ахуй, газар тариалан зэрэг салбарт үйл ажиллагаа эрхэлдэг гэжээ.

График 2. Санал асуулгын судалгаанд оролцогчдын бизнесийн үйл ажиллагаа явуулсан туршлага (жилээр)



Судалгаанд оролцогчдын 32 хувь нь 3 хүртэл жил, 24 хувь нь 4-9 хүртэл жил, 37 хувь нь 10-19 жил, 7 хувь нь 20-иос дээш жил бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байна. Эндээс үзвэл 50 орчим хувь нь бизнесийн үйл ажиллагааг 10-аас дээш жил эрхэлж байгаа туршлагатай, тулгарч буй асуудлуудыг биечлэн шийдвэрлэдэг буюу тухайн бизнесийн үйл ажиллагаагаа мэдэх, удаан хугацаанд үйл ажиллагаагаа эрхэлж байгаа бизнес эрхлэгчдийг хамруулсан болохыг харуулж байна. Мөн ихэнх бизнес нь эхний 3 жилдээ дампуурдаг, үйл ажиллагаагаа зогсоодог гэж үзвэл 4-өөс дээш жил үйл ажиллагаа эрхэлж байгаа нь нийт судалгаанд оролцогчдын 70 орчим хувийг эзэлж байгаа юм.

Түүнчлэн судалгаанд оролцогчдыг эрхэлж буй ажил, албан тушаал болон тухайн салбарт ажилласан жилээр нь харьцуулж үзвэл бүхий л албан тушаалд ажиллагсдын хамгийн багадаа 30-аас дээш хувь нь 10-19 жил (албан тушаалын аль ч ангиллын хувьд 65-аас дээш хувь нь 4-өөс дээш жил) ажилласан туршлагатай байгаа нь тухайн салбарын онцлогыг бүрэн дүүрэн мэддэг, тодорхой хугацаанд бизнесийн салбарт ажиллаж, өөрийн туршлага хуримтлуулсан болох нь харагдах бөгөөд үүнээс тус судалгааны үнэн бодитой байдлын чанарын үзүүлэлт хангалттай түвшинд байгаа гэж дүгнэж болно.

График 3. Санал асуулгын судалгаанд оролцогчдын эрхэлдэг ажил, албан тушаал (давхардсан тоогоор) ба бизнес эрхэлсэн туршлага (жилээр)






График 4. Санал асуулгын судалгаанд оролцогчдын мэргэжлийн болон бизнесийн байгууллагын гишүүнчлэл



Санал асуулгын судалгаанд оролцогчдын 73 хувь нь ямар нэг байдлаар бизнесийн болон мэргэжлийн ТББ-ын гишүүнчлэл байхгүй байна. Харин судалгаанд оролцогчдын 14 хувь нь мэргэжлийн болон бизнесийн чиглэлийн байгууллагуудтай холбоотой байж хамтран ажилладаг бол 8 хувь нь мэргэжлийн болон бусад туслалцааг тус байгууллагуудаас авдаг, 5 хувь нь гишүүн боловч холбоо харилцаатай байдаггүй гэжээ. Энэ нь бизнес эрхлэгчид мэргэжлийн болон бизнесийн байгууллагын гишүүнчлэлд төдийлөн хамрагддаггүй, тэдний хамтын ажиллагаа сул байгааг илэрхийлж байна.

График 5. Санал асуулгын судалгаанд оролцогчдын нэг сарын хугацаанд амаар болон бичгээр хийдэг гэрээ, хэлцлийн дундаж тоо (үйл ажиллагааны салбараар)



Санал асуулгын судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 87.3 хувь нь нэг сарын хугацаанд 50 хүртэлх гэрээ, хэлцлийг хийдэг байна. Харин бизнесийн хэлбэрээр нь харьцуулж үзвэл ХХК болон ХК-ийн 10-15 хувь нь нэг сард 51-100 хэлцэл, 3 орчим хувь нь 100-аас дээш гэрээ, хэлцлийг хийдэг байна. Харин ТӨҮГ-ын төлөөллийн 42.9 хувь нь нэг сард 101-500 гэрээ, хэлцэл хийдэг хэмээн хариулсан байх бөгөөд энэ нь төр худалдан авагч төдийгүй бизнесийн үйл ажиллагааны нэг талын маш идэвхитэй оролцогч байх магадлалтайг харуулж байна.

3.2. Ярилцлагын судалгаанд оролцогчдын мэдээлэл

Ганцаарчилсан ярилцлагын судалгаанд 73 бизнес эрхлэгч тэдгээрийн гол мэдээлэгч (*key informant*) хамрагдаж, мэдээлэл өгсөн болно. Үүнээс бизнес эрхлэгчдийг хуулийн этгээдийн хэлбэрээр нь ангилан авч үзвэл, 91.7 хувь нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, 4.10 хувь нь хувьцаат компани, 2.73 хувь нь нөхөрлөл, 1.36 хувь нь бизнесийн зөвлөгөө өгдөг төрийн бус байгууллага байна. Эдгээр бизнес эрхлэгчдийн 41.09 хувь нь 1-9, 36.9 хувь нь 10-49, 21.9 хувь нь 50-2300 ажилтан (ажилтны тоо)-тай байна.

Ярилцлагын судалгаанд оролцсон гол мэдээлэгч (*key informant*)-дийн 51.7 хувь нь үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, нөхөрлөлийн гишүүн, 9.58 хувь нь гүйцэтгэх удирдлага, 4.10 хувь нь санхүү хариуцсан албан тушаалтан, 17.8 хувь нь

хуулийн зөвлөх, 4.10 хувь нь салбарын захирал, нэгж хариуцсан албан тушаалтан, 10.95 хувь нь ерөнхий менежер, ахлагч, 2.73 хувь нь бусад мэргэжилтнүүд байсан бөгөөд бизнесийн үйл ажиллагаанд оролцогчийн бүхий л төлөөллийг хамруулснаараа энэхүү судалгаа онцлогтой юм. Өөрөөр хэлбэл, эдгээр хүмүүс нь бизнесийн үйл ажиллагааны алхам тутамд гар бие оролцдог тул үүсч буй бэрхшээл, тулгамдаж байгаа асуудлуудыг нээн илрүүлэхэд чухал ач холбогдолтой мэдээллийн эх сурвалж гэж үзэж болно. (хүснэгт 4-өөс харна уу.)

Хүснэгт 4. Ярилцлагын судалгаанд оролцогчдын хүн ам зүйн болон байгууллагын мэдээлэл

№	Ерөнхий агуулга	Тоо	Хувь
Хуулийн этгээдийн хэлбэр			
1	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	67	91,7
2	Хувьцаат компани	3	4,10
3	Нөхөрлөл	2	2,73
4	Төрийн бус байгууллага	1	1,36
Ажилтны тоо			
1	1-9 хүнтэй	30	41.09
2	10-49 хүнтэй	27	36.9
3	50-2300 хүнтэй	16	21.9
Гол мэдээлэгч (key informant)			
1	Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, нөхөрлөлийн гишүүн	37	51.7
2	Гүйцэтгэх удирдлага	7	9.58
3	Санхүү хариуцсан албан тушаалтан	3	4.10
4	Хуулийн зөвлөх	13	17.8
5	Салбарын захирал, нэгж хариуцсан албан тушаалтан	3	4.10
6	Ерөнхий менежер, ахлагч	8	10.95

Судалгаанд оролцогчдын бизнесийн үйл ажиллагааны салбарыг ангилахын тулд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомжийг баримталсан бөгөөд Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан тушаалаар “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”⁵ -ын шинэчилсэн хувилбарыг баталжээ.

Тус ангиллын дагуу судалгаанд оролцогчдын үйл ажиллагааны салбарын ангиллыг харуулбал, 31.5 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 19.17 хувь нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, 13.69 хувь нь уул уурхай, олборлолт, 9.58 хувь нь мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, 6.84 хувь нь барилга, 4.1 хувь нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 4.1 хувь нь хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ, 4.1 хувь нь тээвэр, агуулахын үйл ажиллагаа, 1.36 хувь нь үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, 1.36 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас, ан агнуур, 1.36 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 1.36 хувь нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны газрын үйл ажиллагааг эрхэлж байна. (график 4-өөс харна уу.)

График 6. Ярилцлагын судалгаанд оролцогчдын үйл ажиллагааны салбарын ангилал



Иймд Монгол Улсад Арилжааны хуулийн хэрэгцээ шаардлага байгаа эсэх, түүнд холбогдох одоогийн нөхцөл байдал, бизнес эрхлэгчдийн санаа бодлыг

⁵ Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2018 оны 319, А/160 дугаар тушаалын хавсралт

тандах зорилгоор бизнес эрхэгчдийн гол мэдээлэгч (*key informant*)-ээс ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээллийг цуглуулсан болно.

ДӨРӨВ. БИЗНЕС ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХЭЛЦЛИЙН БАТАЛГААТ, ТҮРГЭН ШУУРХАЙ БАЙДАЛ, АШГИЙН ТӨЛӨӨХ ЗОРИЛГЫГ ХАНГАХ АСУУДАЛ


Энэ хэсэгт судалгааны үндсэн хэсэг болох бизнес эрхлэгчид тулгарч болох асуудал тус бүрээр нь бизнес эрхлэгчийн үйл ажиллагааны ашгийн төлөөх зорилгыг хангах байдал, хэлцлийн түргэн, шуурхай, баталгаат байдлын талаарх эрх зүйн зохицуулалтыг тус бүрд нь асуулт хэлбэр оруулж санал асуулгыг боловсруулсан болно.

Санал асуулгын асуултууд нь зарим төрлийн бизнес эрхлэгчид илүү хамааралтай, зарим тохиолдолд хамааралгүй эсхүл хуулийн нарийн мэдлэг шаардсан асуултууд багтсан болно. Иймд зөвхөн нийт судалгаанд оролцогчдийн хариултад үндэслэн судалгааны дүгнэлтийг хийх нь зарим тохиолдолд үнэн, бодитой байдлыг тодорхойлоход хангалтгүй байх тул судалгааны дүгнэлтийг 1) Нийт судалгаанд оролцогчид хэрхэн дүгнэж байгаа, 2) Тухайн салбарын мэргэжлийн субъект эсхүл үйл ажиллагааны чиглэлээс хамааран тухайн бизнес эрхлэгч (жишээлбэл, хуульч, эрх бүхий албан тушаалтан эсхүл худалдааны үйл ажиллагаа эрхлэгч) хэрхэн дүгнэж байгааг ялгамжтайгаар авч үзэх ёстой. Судалгааны энэ хэсэгт асуулт бүрийг дээрх 1, 2 дахь хэсгүүдэд заасан ангиллаар тус бүрт нь дүгнэлт хийхийг оролдсон болно.

4.1. Хувиараа бизнес эрхлэгчийн арилжааны нэр

Санал асуулгад оролцогчдыг субъектээр нь авч үзвэл, хувиараа бизнес эрхлэгч өөрийн гэсэн арилжааны нэр (*commercial/trade name*)-тэй байх шаардлагатай хэмээн нийт оролцогчдын 50-аас дээш хувь (дунджаар 70 шахам хувь) нь үзсэн байх бөгөөд эдгээрээс гүйцэтгэх удирдлага болон хуулийн асуудал хариуцсан албан тушаалтнууд хамгийн өндөр хувь буюу дунджаар 78.5 (82.5+75) хувь нь дэмжсэн байна. Өөрөөр хэлбэл, аливаа бизнес эрхлэгчийн нэрийн өмнөөс гэрээ хэлцэл байгуулдаг гол субъект нь гүйцэтгэх удирдлага, тэдгээрт гэрээ хэлцэл байгуулахад нь хууль зүйн зөвлөгөө үзүүлдэг хуульчдын дийлэнх олонх нь хувиараа бизнес эрхлэгч арилжааны нэртэй байх шаардлагатай гэж хариулсан байгаа нь арилжааны нэр нь тухайн бизнес эрхлэгчийг таньж мэдэхэд чухал ач холбогдолтой тул хэлцлийн баталгаат байдалд эерэгээр нөлөөлдөг гэж дүгнэж болохоор байна.

График 7. Хувиараа бизнес эрхлэгч иргэн нь бизнес эрхлэхдээ хэрэглэдэг өөрийн хамгаалагдсан нэртэй байх хэрэгцээ, шаардлага



4.2. Үл өрсөлдөх үүргийг хуульчлах асуудал

Олон улсын бизнесийн практикт үл өрсөлдөх үүрэгтэй холбоотойгоор 2 асуудал яригдаж байна. Нэгдүгээрт, аливаа бизнес эрхлэгч нь өөрийн эрхлэн байгаа бизнесээ бусад бизнес эрхлэгчид бүрэн шилжүүлсэн тохиолдолд, тухайн шилжүүлсэн бизнесийн үйл ажиллагаантай өрсөлдөхүйц ижил төрлийн бизнесийн үйл ажиллагаа явуулахгүй байх үүргийг хүлээдэг бөгөөдүүнийг хуулиар хориглох нь түгээмэл байна.


Хоёрдугаарт, бизнесийн байгууллагад удирдах албан тушаалд ажиллаж, тухайн бизнесийн талаар тусгайлсан мэдээлэлтэй болсон этгээд (гүйцэтгэх удирдлага г.м.) тухайн бизнесийн байгууллагаас гарч, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг бизнесийн байгууллагад ажиллах болсон эсхүл өрсөлдөхүйц ижил төрлийн бизнесийн үйл ажиллагаа өөрөө эрхлэх тохиолдолд асуудал гарч ирдэг. Манай улсын хувьд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг судлан авч үзвэл энэ талын зохицуулалт дутмаг байх тул Монгол Улсад энэ асуудлыг хэрхэн зохицуулах нь зүйтэйг судалгаанд үндэслэн гаргаж ирэхийг оролдсон болно.

Энэ зорилгын хүрээнд “Танай байгууллагын удирдах албан тушаалтан, эсхүл бизнесийн нууц мэдэх ажилтан өрсөлдөгч аж ахуйн нэгжид ажиллах, адил төрлийн бизнес эрхлэх зэргийг тодорхой хугацаанд хуулиар хязгаарлах, хориглох шаардлага байна уу?” гэсэн асуултыг тавихад нийт судалгаанд оролцогчдын дунджаар 40.7 хувь нь үл өрсөлдөх үүргийг хуулиар зохицуулах шаардлагатай гэж хариулсан бол үлдсэн хувь нь мэдэхгүй болон шаардлагагүй гэсэн хариултыг өгсөнийг График 8-аас харж болно. Үл өрсөлдөх үүргийн зохицуулалт нь илүүтэй хууль зүйн асуудал гэж үзэн уг асуултад хуульч, өмгөөллийн байгууллагын

оролцогчид хэрхэн хариулсаныг доорх графикаас харахад хуулийн зөвлөгөө, өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлдэг оролцогчдын 82.4 хувь нь өрсөлдөхгүй байх үүргийг хуульчлах шаардлагатай гэж хариулсан. Үүнээс үзэхэд бизнесийн практикт энэ төрлийн зөрчил, асуудал их үүсдэг, эсхүл үүнээс сэргийлэх ёстой гэж мэргэжлийн хүмүүс үзэж байна гэсэн дүгнэлт хийж болох юм.

Түүнчлэн энэхүү үл өрсөлдөх асуудал нь зөвхөн бизнесийн байгууллагын удирдлагын түвшинд ажиллаж байсан этгээд тухайн бизнес эрхлэгчтэй өрсөлдөхгүй байх үүргийг хүлээхээс гадна бизнесээ бусдад шилжүүлсэн, худалдсан этгээдэд ч мөн хамааралтай байдаг талаар дээр дурдсан билээ. Тиймээс энэхүү асуултад нийт хуульч, өмгөөлөгчийн 80-аас дээш хувь нь үл өрсөлдөх үүргийг хуульчлах, нийт оролцогчдийн 40-өөс дээш хувь нь тус асуудлыг зохицуулах шаардлагатай гэж хариулсан байна.

График 8. Үл өрсөлдөх үүргийг хуульчлах шаардлага




4.3. Төлөөлөх бүрэн эрхийн асуудал

Бизнес эрхлэгчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй субъект нь Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид зааснаар зөвхөн гүйцэтгэх удирдлага

байхаар зохицуулсан зохицуулалтаас үүдэлтэй маргаантай асуудлууд гарч байгаа талаар судалгаанд оролцогчид шүүхийн практикийг судлахад түгээмэл байдаг. Хуулийн этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдэд хамаарахгүй бусад албан тушаалтны аливаа үйл ажиллагаа, хэлцэлд бизнес эрхлэгчийг төлөөлөх тухайлсан бүрэн эрх буюу хуульд заасан хэлбэрээр итгэмжлэл олгох замаар эрх олгох бус ерөнхийлсөн буюу итгэмжлэлгүйгээр хэрэгжүүлэх боломжтой бүрэн эрхтэй эсэх, түүний төлөөлөх бүрэн эрхийн хэмжээ, хязгаарын талаар зохицуулсан хэм хэмжээ гадаадын олон улсад хангалттай нарийн хуульчлагдсан байдаг.

Үүнтэй холбоотойгоор судалгаанд оролцогчид бизнес эрхлэгчийн төлөөллийн асуудалд хэрхэн хандаж байгаа талаар авч үзье. Та гэрээ, хэлцлийг жинхэнэ эзэнтэй нь биш төлөөлөгч, итгэмжлэл бүхий этгээдтэй нь хийх тохиолдолд үүсч болох эрсдлийг зохицуулсан одоогийн эрх зүйн зохицуулалт хангалттай гэж үзэж байна уу? (График 9) гэсэн асуултад нийт судалгаанд оролцогчдын 57 хувь нь итгэмжлэлгүйгээр төлөөлөх зохицуулалт хангалтгүй гэдэгт санал нэгдсэн ба харин илүү мэргэшсэн оролцогчид болох хуульч, санхүү хариуцсан албан тушаалтны 62-оос дээш хувь нь одоогийн эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна гэж дүгнэсэн. Үүнээс үзэхэд итгэмжлэлгүйгээр төлөөлөх асуудал нь зөвхөн хууль зүйн хүрээнд бус санхүү хариуцсан албан тушаалтны дунд ч асуудал болдог болох нь тодорхой байна.

График 9. Төлөөлөгч, итгэмжлэл бүхий этгээдтэй холбогдох одоогийн эрх зүйн зохицуулалт хангалттай эсэх



Бизнес эрхлэгчдийн хувьд олон тооны хэлцэл хийдгийг энэхүү судалгаанд оролцогчдын хариултаас харж болох ба тэдгээр хэлцлийн баталгаат байдал буюу

гэрээ, хэлцэл хийгдсэний дараа ямар нэгэн маргаанаас бүрэн хамгаалагдсан байх шаардлага зүй ёсоор тавигддаг. Энэ хүрээнд олон хариулт сонгож болох хувилбартайгаар “Та үл хөдлөх хөрөнгө, лиценз, газар, хувьцаа худалдаж авах г.м. тохиолдолд өмнө нь өмчлөгч, эзэмшигч байсан гуравдагч этгээдийн маргах эрсдэлээс бүрэн хамгаалагдсан гэж үзэж байна уу? Хамгаалагдаагүй бол ямар шалтгаантай вэ?” гэсэн асуулт тавьсан болно.

Энэ талаар судалгаанд оролцогч бизнес эрхлэгчид аливаа хөрөнгө худалдаж авах тохиолдолд өмнөх өмчлөгч, эзэмшигч маргах эрсдэлээс хамгаалагдсан хэмээн 10%, тодорхой мэдээлэлгүй буюу мэдэхгүй бүлэг хамгийн өндөр 33.7% байна (График 10-ыг харна уу). Харин эрсдлээс бүрэн хамгаалагдаагүй гэж үзсэн оролцогчид 2 үндсэн шалтгаантай байна. Үүнд: Нэгдүгээрт, “бизнес эрхлэгчид энэ талын мэдлэг хангалтгүй бөгөөд хууль зүйн зөвлөгөө авдаггүйтэй холбоотой”, Хоёрдугаарт, “үүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалт хангалтгүй” гэсэн байна. Ийнхүү бусад шалтгаан гэсэн хэсгийг 1 хүрэхгүй хувь бөглөсөн нь үндсэн 2 шалтгаантай гэсэнтэй нийцэж байгаа болно.


График 10. Үл хөдлөх хөрөнгө, лиценз, газар, хувьцаа худалдаж авах г.м. тохиолдолд өмнө нь өмчлөгч, эзэмшигч байсан гуравдагч этгээдийн маргах эрсдэлээс бүрэн хамгаалагдсан эсэх, хамгаалагдаагүй бол шалтгаан



Төлөөлөлтэй холбоотой авч үзэх дараагийн асуудал нь бизнес эрхлэгчийг төлөөлөхтэй холбоотойгоор бизнесийн байгууллагын хувьд дан ганц гүйцэтгэх захирал итгэмжлэлгүйгээр төлөөлөх бүрэн эрхтэй байгаагаас компанийн бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх тухай асуудал юм. Компанийн үйл ажиллагаа хариуцсан захирал, хүний нөөц хариуцсан захирал, хууль, эрх зүйн газрын захирал, борлуулалтын албаны дарга (гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлж байсан ч эдгээр нь итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхгүй) гэх мэт албан тушаалын олон шатлал болдог. Эдгээр албан тушаалтны хувьд компанийн үйл

ажиллагааны тодорхой нэг хэсэгт холбогдох хэлцэл (өөрийн салбарт холбогдох, эсхүл маркетингийн газрын захирал зар сурталчилгааны компанитай гэрээ хийх г.м.) хийх, шүүхийн бус (мөн шүүх, арбитрын процесс) аливаа үйл ажиллагаанд төлөөлөх бүрэн эрхийг практикт бодитой эдэлж байна. Үүнийг тодорхой жишээн дээр авч үзвэл, А банкны Говь-Алтай аймаг дахь салбарын захирал нь томоохон засвар хийх (банкийг төлөөлөн хэлцэл хийсэн гэж үзнэ) гэрээ байгуулсан боловч дараагаар нь салбарын захиралд бие даан гэрээ байгуулах эрх олгогдоогүй буюу төлөөлөх бүрэн эрхгүй этгээд гэж банкны зүгээс маргасан тохиолдол шүүхийн практикт гарч байсныг дурдаж болох юм. Энэ хүрээнд “Танай байгууллагын хувьд бүх гэрээ, хэлцэл нэг хүн буюу гүйцэтгэх захирлаас хамааралтай байх нь бизнесийн үйл ажиллагааны түргэн шуурхай байдалд нөлөөлдөг үү?” гэсэн асуулт тавьсан болно. Өөрөөр хэлбэл, эрх зүйн зохицуулалтын хувьд хуулийн этгээдийг зөвхөн гүйцэтгэх захирал итгэмжлэлгүйгээр төлөөлөхөөр заасан нь бодит байдалд хэрхэн нийцэж байгааг доорх графикаас харж болно.

График 11. Хуулийн этгээдийн бүх гэрээ, хэлцэл нэг хүн буюу гүйцэтгэх захирлаас хамааралтай байх нь бизнесийн үйл ажиллагааны түргэн шуурхай байдалд нөлөөлөх байдал




Бизнес эрхлэгчдийн хийх гэрээ, хэлцэл нь дан ганц гүйцэтгэх захирлаас хамааралтай байх нь бизнесийн үйл ажиллагааны түргэн шуурхай байдалд нөлөөлдөг эсэхэд 25 хувь нь “хэлж мэдэхгүй”, 29 хувь нь “нөлөөлдөг, хүндрэлтэй байдаг” гэсэн бол 36 хувь нь “нөлөөлдөггүй, боломжийн байдаг” хэмээн хариулжээ. Үүнд дүн шинжилгээ хийвэл, бүх гэрээ, хэлцэлд гарын үсэг зурах буюу гэрээ байгуулах эрх нэг албан тушаалтанд төвлөрөх нь хэлцэл хийх хурданд нөлөөлдөггүй гэж хамгийн олон оролцогч хариулсан байдаг. Ийнхүү хариулах хэд хэдэн шалтгаан байж болох бөгөөд жишээлбэл, хэлцлийн талуудын итгэлцэл доогуур байгаагаас үүдэн хэт олон хүнд гэрээ байгуулах эрх олгох нь хянах боломжгүй байдалд хүргэж болзошгүй, мөн тодорхой үйл ажиллагааны чиглэлийг

эс тооцвол олон салбарт үйл ажиллагаа явуулдаггүйтэй холбоотой, мөн үйл ажиллагаа нь өргөн хүрээ далайцтай болоогүйтэй холбоотой байж болох юм.

Тэгвэл дээрх асуултын талаар судалгаанд оролцогчдыг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл мал аж ахуй, газар тариалангийн салбар хамгийн өндөр буюу 55.6 хувь нь бизнесийн үйл ажиллагааны түргэн шуурхай байдалд нөлөөлдөг гэж үзсэн байна. Үүний шалтгаан нь мал аж ахуй, газар тариалан нь дийлэнхдээ хотоос алслагдсан зайд буюу орон нутагт төвлөрдөг учир гүйцэтгэх захирал байнгын нэг газраа төвлөрөн ажиллах боломжгүй байдагтай холбоотой гэж үзэж болохоор байна.

Харин улс даяар хамгийн олон салбар, нэгжтэй бизнесийн байгууллага болох банк, санхүү, даатгалын салбарын хувьд 25.9 хувь нь хүндрэлтэй байдаг гэсэн бол нийт оролцогчдоос хамгийн өндөр буюу 25.9 хувь нь нэгээс олон хүнд гэрээ байгуулах эрх олгогдсон байдаг гэж тус салбарынхан хариулжээ. Үүний шалтгаан нь банк, санхүүгийн байгууллага гэрээ, хэлцэл байгуулахад зөвхөн гүйцэтгэх захирал гэрээ байгуулах эрхтэй байх буюу нэг хүнээс хамааралтай байх нь зээл олгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зэрэг байнгын шинжтэй, дахин давтагддаг үндсэн үйл ажиллагаанд саад учруулах эрсдэлтэй тул үүнийг урьчдиглан тооцож хуульд заасан боломжийг ашиглан салбарын захирал, менежерүүдэд тодорхой бүрэн эрх буюу итгэмжлэл олгох байдлаар зохицуулдаг гэж дүгнэж болохоор байна.

График 12. Хуулийн этгээдийн бүх гэрээ, хэлцэл нэг хүн буюу гүйцэтгэх захирлаас хамааралтай байх нь бизнесийн үйл ажиллагааны түргэн шуурхай байдалд нөлөөлөх байдал



Түүнчлэн судалгаанд оролцогчдоос бодит практик асуухад “*өөрсдийн мэддэг байгууллагуудад гэрээ, хэлцэл байгуулах эрхээ олон хүнд шилжүүлж олгосон байдаг*” гэсэн сонголтыг 10 орчим хувь дэмжсэн байна. Энэ нь хэлцэл хийх эрхийг нэгээс олон этгээдэд өгдөг бизнесийн практик байгаа болохыг харуулж буй юм. Үүнийг бизнесийн үйл ажиллагааны эрхлэх хэлбэрээр нь авч үзвэл дараах үр дүн гарч байна. /Хүснэгт 5/

Хүснэгт 5. Хуулийн этгээдийн бүх гэрээ, хэлцэл нэг хүн буюу гүйцэтгэх захирлаас хамааралтай байх нь бизнесийн үйл ажиллагааны түргэн шуурхай байдалд нөлөөлөх байдал (бизнес эрхэлж буй хэлбэрээр)

№	Бизнесийн хэлбэр	Нөлөөлдөг, хүндрэлтэй байдаг	Нөлөөлдөггүй, боломжийн	Мэдэхгүй	Өөр байгууллагуудад олон хүнд гэрээ байгуулах эрх олгогдсон байдаг
1	ХХК	31.9%	42.8%	13.8%	11.6%

2	ХК	41.4%	31.0%	20.7%	6.9%
3	ТӨҮГ	25.0%	25.0%	37.5%	12.5%
4	Хувиараа бизнес эрхлэгч	25.7%	35.1%	29.8%	9.4%
5	Хоршоо	33.3%	33.3%	33.3%	
6	Нөхөрлөл	52.4%	33.3%	4.8%	9.5%
7	Бусад	15.2%	30.3%	36.4%	18.2%

Дээрх хүснэгтийн тоон үзүүлэлтийг нэгтгэвэл ХК болон Нөхөрлөлийн хувьд гэрээ, хэлцэл нь нэг хүнээс хамааралтай байх нь үйл ажиллагаанд нь “*нөлөөлдөг, хүндрэлтэй байдаг*” гэсэн бол хязгаарлагдмал хариуцлагатай компани болон хувиараа бизнес эрхлэгчид “*нөлөөлдөггүй, боломжийн*” гэсэн байна. Харин “*нөлөөлдөг*” гэж хариулсан бизнес эрхлэгчдийн харилцан итгэлцлийн талаарх асуудлыг хөндөхөд, энэ талаар эрх зүйн зохицуулалт туйлын хангалтгүй, сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна.

Бизнес эрхлэгчийн зорилго нь аль болох түргэн, шуурхай хэлцэл хийх (гэрээний үүргийн гүйцэтгэлээ яаралтай эхлүүлж, үүргээ биелүүлж дуусгахын тулд) шаардлагатай байдгаас нэг талаас бизнесийн байгууллагад цор ганц байдаг гүйцэтгэх захирлаас нэг бүрчилсэн агуулгатай төлөөлөх эрх олгосон итгэмжлэлийг зохих этгээдэд (салбарын захирал г.м.) тухай бүр олгох нь цаг хугацаа, орон зай, бодит боломжийн хувьд өндөр зардалтай, эрсдэлтэй (хэлцэл байгуулахыг нөгөө тал хүлээх боломжгүйгээс хэлцэл хийгдэхгүйд хүрч болно) зэрэг учир шалтгаанаас энэ асуудлыг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээг тодорхой болгох, практикт төвөг чирэгдэл багатай болгох шаардлагатай байдаг.

Ярилцлагын судалгаанаас үзэхэд Монгол Улсын хувьд ихэнх тохиолдолд зөвхөн гүйцэтгэх захирлыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх бүрэн эрхтэй этгээд гэж тайлбарлах байдлаар бусад этгээдийн бүрэн эрхийг ерөнхий байдлаар бус тусгайлсан (нэг бүрчилсэн үйлдэл хийх) байдлаар зохицуулах нь түгээмэл байна. Гэтэл эдгээр нэгжийн захирал, менежер, дарга гэх мэт албан тушаалтай этгээд нь бусадтай гэрээ байгуулах, хэлцэл хийх тохиолдолд тэдгээрийн төлөөлөх бүрэн эрх (жишээлбэл, бүрэн эрхийн хэмжээ хязгаар)-ийг тодорхойлоогүйгээс хэлцэл хийж буй гуравдагч этгээд төдийгүй, үүнээс үүдэн арилжаа, бизнесийн үйл ажиллагааны тогтвортой, түргэн шуурхай явагдах, найдвартай байдал хангагдахад тодорхой хүндрэл учирч байна.

Практикт дээрх харилцааг тухайн хуулийн этгээдийн дүрэм, гэрээ, дотоод журмаар зохицуулж байгаа бөгөөд үүнийг тухайн хуулийн этгээдтэй хэлцэл байгуулах гэж буй бизнес эрхлэгч мэдэх, нягтлах боломжгүй байдаг. Иргэний хуулийн төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн хэлцлийн талаарх зохицуулалт


нь иргэд хоорондын хэлцлийн талаарх зохицуулалт бөгөөд энэ нь бизнес эрхлэгч хоорондын хэлцлийн харилцаанд төдийлөн тохиромжгүй юм. Учир нь Иргэний хууль дахь зохицуулалт нь бизнес эрхлэгчийн тодорхой онцлогийг тусгаагүй байна. Мөн хувиараа бизнес эрхэлж байгаа этгээдийн хувьд өөрийн эрхэлж буй үйл ажиллагааны тодорхой хэсгийг бусад этгээдэд бүрэн эрх олгох байдлаар хэрэгжүүлсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар мөн нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. Зарим практик хуульчид нэгэнт эрх олгогдсон (төлөөлөх ерөнхий бүрэн эрхтэй) гэж нөгөө тал итгэсэн (өөрөөр хэлбэл, нэг тал нь тийнхүү итгэл төрүүлсэн) бол тухайн этгээдэд төлөөлөх эрхийг бичгээр олгосон эсэхээс үл хамааран хэлцэл хүчин төгөлдөр байх итгэлийг хамгаалах зарчим олон улсад үйлчилдэг тухай дурдаж байсан болно.

4.4. Хөөн хэлэлцэх хугацаа

Хөөн хэлэлцэх хугацаа нь эрх зүйн харилцаанд баталгаат байдлыг бий болгох, тодорхой хугацаа өнгөрснөөр маргаан гарах эрх зүйн боломжгүй болох нөхцөлийг бүрдүүлдэг. Үүрэг гүйцэтгэгч тодорхой хугацаа өнгөрсний дараа хуучирсан өр, үүрэг нэхэгдэхээс хамгаалагдах ёстой ба энэ нь шударга ёсонд нийцнэ гэж үздэг. Учир нь хэлцэл хийснээс хойш хугацаа өнгөрөх тусам үүрэг гүйцэтгэгч өөрийгөө хамгаалах бодит боломжгүй болж, үйл явдал бүдгэрдэг. Иймд аливаа хэлцлийн эрх зүйн үр дагавар тодорхой хугацаа өнгөрснөөр бүрэн үгүй болох нөхцөл байдал нь хөөн хэлэлцэх хугацаатай холбогддог бөгөөд эрх зүйн харилцааны онцлогийг харгалзан хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтайгаар хуулиар тогтоодог.

Энэ хүрээнд бизнес эрхлэгчдийн хоорондын хэлцлийн харилцаа түргэн, шуурхай, хариуцлагатай байхад үндэслэдэг тул иргэд хоорондын хэлцлээс үүсэх шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаанаас илүү богино хугацааг тогтоодог жишиг олон улсад байна. Өөрөөр хэлбэл, хоёр иргэний хооронд хийгдэх гэрээ хэлцэл, иргэн бизнес эрхлэгч, бизнес эрхлэгч бизнес эрхлэгчтэй хийх хэлцлээс үүсэх харилцааны хувьд талуудын хүлээх үүрэг, хүчин төгөлдөр байх хугацаа нь нэгэн адил байхаас илүүтэй, ялгамжтай авч үзэх нь зохистой гэж үзсээр ирсэн байдаг. Иймд судалгаанд оролцогчид “Бизнес эрхлэгч хоорондын гэрээний хөөн хэлэлцэх хугацаа 3 жил байгаа бөгөөд гомдлын шаардлага гаргах хугацаа дууссанаас хойш уг хугацааг тоолдог нь бизнесийн харилцааны хувьд хэр оновчтой вэ?” гэсэн асуултад хэрхэн хариулсныг (График 12) тодруулан авч үзье.

График 13. Бизнес эрхлэгч хоорондын гэрээний хөөн хэлэлцэх хугацаан дээр нэмж гомдлын шаардлага гаргах хугацааг тоолдог нь бизнесийн харилцаанд оновчтой эсэх



Гэрээний хөөн хэлэлцэх хугацаан дээр нэмж гомдлын шаардлага гаргах хугацааг тусад нь тоолох нь оновчтой хэмээн судалгаанд оролцогчдын 14 хувь нь үзсэн бол харин эсрэгээр гомдлын шаардлага гаргах хугацаа нь хөөн хэлэлцэх хугацаандаа багтах нь зүйтэй гэж 11 хувь үзсэн байгаа (График 12) нь энэ талаар тухайлан дүгнэлт хийх боломжгүй болгож байна. Гэхдээ одоогийн байгаа эрх зүйн зохицуулалтыг дэмжсэн 14 хувиас өөрчлөхийг дэмжсэн хувь илүү (хугацааг богиносгох-12 хувь, уртасгах-26 хувь, тоолох аргыг өөрчлөх-11 хувь, буюу нийт 49 хувь) байгааг анхаарах нь зүйтэй юм. Хандлагын хувьд хугацааг богиносгох (хугацааг богиносгох-12 хувь, тоолох аргыг өөрчлөх-11 хувь, нийт 23 хувь) болон илүү урт болгох (26 хувь) талаар бизнес эрхлэгчид ойролцоо байр суурьтай байгаа нь судалгаанд оролцсон тухайн оролцогчийн туршлагатай холбоотой байж болох юм.

Судалгаанд оролцогчдын 37 хувь нь бизнес эрхлэгчдийн хооронд байгуулагдаж буй гэрээ, хэлцлийн хөөн хэлэлцэх хугацаа (3 жил) урт, богино байгаа эсэхэд тодорхой санал гараагүй буюу “мэдэхгүй” хэмээн хариулсан нь энэ талаар ямарваа нэг практик туршлага байхгүйтэй холбоотой байж болох юм. Нийтлэг тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа нь өдөр тутам амьдралд хэрэглэгдэхгүй, зөвхөн маргаан гарсан тохиолдолд шүүхэд хандах боломжтой буюу шаардах эрхээ хэрэгжүүлэх боломжтой эсэхэд хариулт өгдөг учир энэхүү асуултад хуульч, өмгөөлөгчид ямар байр суурьтай байгааг тодруулах нь илүү оновчтой юм.

График 14. Бизнес эрхлэгч хоорондын гэрээний хөөн хэлэлцэх хугацаан дээр нэмж гомдлын шаардлага гаргах хугацааг тоолдог нь бизнесийн харилцаанд оновчтой эсэх (ажил, албан тушаалаар)




График 13-аас харахад судалгаанд оролцогчдийн дийлэнх нь хөөн хэлэлцэх хугацааг уртасгах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд хуульчдын 50 хувь нь мөн адил хөөн хэлэлцэх хугацааг уртасгах нь зүйтэй гэсэн нь анхаарал татаж байна. Энэ хүрээнд хэрэглэгч болон бизнес эрхлэгчид хамааралтай хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай тогтоох (энэ тохиолдолд хэрэглэгчийн гэрээнд хамаарах хөөн хэлэлцэх хугацааг сунгах) эсхүл бүхий л хөөн хэлэлцэх хугацааг сунгах (энэ тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг адил байхаар сунгах, эсхүл хөөн хэлэлцэх хугацааг сунгахдаа хэрэглэгчийн гэрээний хөөн хэлэлцэх хугацаа нь бизнесийн хэлцлийн хөөн хэлэлцэх хугацаанаас урт байх) гэсэн 2 хувилбар яригдах боломжтой болохыг судалгаанд оролцогчид дэмжсэн байхыг үгүйсгэхгүй юм.

4.5. Хэлцлийн хэлбэрийн шаардлагын асуудал

Хэлцлийн хэлбэрийн шаардлага нэрлэсэн гэрээний төрлөөс хамааран амаар эсхүл бичгээр байдаг ба энэхүү хэлбэрийн шаардлагыг хангаагүй хэлцэл хүчин төгөлдөр бус байх үр дагавартай болдог. Гэхдээ хэлбэрийн шаардлага нь нэг талаас хэлцлийн түргэн, шуурхай байдалд нөлөөлж хугацаа алдахад хүргэх хэдий ч нөгөө талаас хэлцлийн талуудын баталгаат байдлыг хамгаалахтай зөрчилдөх тохиолдол ч бий. Тиймээс хууль тогтоогч эл нөхцөл байдлуудыг харгалзах, тэнцвэрт байдлыг оновчтой олох нь эдийн засгийн үйл ажиллагаа саадгүй явагдахад ихээхэн нөлөөлөх юм.

Зарим төрлийн гэрээг бичгээр байгуулах хэлбэрийн шаардлагыг өөрчлөх (илүү хялбарчилсан, түргэн шуурхай байдлыг дэмжиж амаар байгуулахыг

зөвшөөрөх)-ийг ерөнхийд нь дэмжих эсэхийг энэ судалгааны хүрээнд тандсан бөгөөд энэ нь дээр дурдсанаар талуудыг маргахаас урьдчилан сэргийлэх, хэлцлийн баталгаат байдлыг дээшлүүлэхтэй холбогдох тул бизнес эрхлэгчдийн байр суурийг анхаарах ёстой юм. Ингэхдээ баталгаат байдлыг бодолцсон хувилбарын талаар саналыг асуусан болно. Тодруулбал, тодорхой хугацааны туршид хамтран ажилласан туршлагатай, бие биенээ мэдэх (хэлцлийн нөгөө талын эрх зүйн байдлыг тодорхой хэмжээгээр мэдэх тул энэ талын эрсдэл бага) бизнес эрхлэгчдэд заавал бичгээр гэрээ байгуулах шаардлагыг тавилгүйгээр, тэдгээрийн хоорондын тохиролцоог хууль зүйн хувьд хүчин төгөлдөр болгох аман хэлбэрийг зөвшөөрөх эсэхийг энэ хүрээнд тандсан болно.

Бизнес эрхлэгчид олон жилийн турш харилцсан хамтрагчтайгаа бичгээр бус аман хэлбэрээр гэрээ байгуулахыг зөвшөөрсөн зохицуулалт бий болбол хэр дэмжин ашиглах (Олон жилийн турш харилцсан хамтрагчтайгаа бичгээр бус аман хэлбэрээр гэрээ байгуулахыг зөвшөөрсөн эрх зүйн зохицуулалт бий болбол Та хэр ашиглах вэ?) талаар байр суурийг тандвал тэдний 41 хувь нь ер нь дэмжихгүй, бичгээр байх нь зүйтэй, 14 хувь нь дэмжинэ гэсэн бол 45 хувь нь (17+28) эрсдэл бага бол эсхүл дараа нь бичгийн хэлбэрт оруулах бол дэмжиж болно гэсэн байр суурийг илэрхийлсэн байна. (График 14)

Шигтгээ 1. "А" ХК-ийн хуулийн албаны даргатай хийсэн ярилцлагаас

... Бизнесийн харилцаанд холимог төрлийн болон нэрлэгдээгүй олон гэрээ хийгддэг, бүгд л ашгийн төлөө зорилготой. Тухайлбал, улаанбуудайн ургацаа хавар тариалахад зориулж мөнгөн урьдчилгаа өгч, намар хураалтын үед улаанбуудай тухайн дүндээ тааруулж нийлүүлдэг ба хэрвээ улаанбуудай ургаагүй эсхүл хэмжээндээ хүргэж нийлүүлж чадахгүй бол арилжааны банкны дундаж хүүтэйгээр авсан урьдчилгаагаа буцаан төлөх харилцаа байдаг. Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ үндсэндээ хийгдэж байгаа боловч гэрээний үүргээ биелүүлэхгүй байхад Зээлийн гэрээ болох боломжтой байхаар тохиролцсон байхад нотариатаар гэрчлүүлээгүй, үүрэг өөрчлөгдсөн гэж үзэхгүй гэдэг үндэслэлээр хүү авах эрхээ алдах жишээтэй байдаг.

График 15. Олон жилийн турш харилцсан хамтрагчтайгаа аман хэлбэрээр гэрээ байгуулахыг зөвшөөрсөн эрх зүйн зохицуулалтыг дэмжих эсэх



Шигтгээ 2. “М” ХХК-ийн захиралтай хийсэн ярилцлагаас

... Бүх л гэрээ хэлцлийг заавал бичгээр хийхийг шаарддаг эсхүл баталгаажуулах (жишээ нь нотариат) хэрэгтэй байдаг нь цаг зав, хөрөнгө мөнгө, хүч хөдөлмөр барсан төвөгтэй ажил байдаг. Бидний хувьд улирлын шинжтэй үйл ажиллагаа эрхэлдэг учраас тариалалтын болон хураалтын хугацаанд цаг хугацаа, хүч хөдөлмөр ихээхэн чухал тул заавал гэрээ хэлцлийг баталгаажуулахгүйгээр хүчин төгөлдөр болгох боломжийг бүрдүүлж өгөх нь зүйтэй байна.

Шигтгээ 3. “KPMG Mongolia Audit” ХХК-ийн татварын ахлах мэргэжилтэн, хуульчтай хийсэн ярилцлагаас

... E market, E худалдаа, цахим баримт бичиг болон цахим гарын үсэг хэрэглэх зэрэг харилцааг зохицуулсан, бизнес эрхлэгчийн өдөр тутмын үйл ажиллагаанд эдгээрийг хэрэгжүүлэхэд төхөм болохуйц нарийвчилсан зохицуулалтууд шаардлагатай байна.

Энэхүү асуултын хувьд өмнө дурдсанаар хуульд бичгээр байгуулах хэлбэрийн шаардлага тавьсан зарим төрлийн гэрээний хувьд тэрхүү хэлбэрийн шаардлагыг цөөрүүлэх, хэлбэрийн шаардлага хангаагүй гэсэн үндэслэлээр шударга бизнес эрхлэгчийн хийсэн гэрээ хүчин төгөлдөр бус болохоос сэргийлэх шаардлагатай эсэх, эсхүл бизнес эрхлэгчийн байгуулсан хэлцлийг хамгаалах шаардлага бий эсэхийг тодруулах зорилготой юм. Энэ хүрээнд дээр дурдсан бизнес эрхлэгчид олон жилийн турш харилцсан бизнес эрхлэгчтэй бичгээр бус

аман хэлбэрээр гэрээ байгуулахыг зөвшөөрсөн зохицуулалт бий болгохыг дэмжээгүй 41 хувийн бизнес эрхлэгчдийн байр суурьт анализ хийж үзье.

Зарчмын хувьд хэлцлийн хэлбэрийн шаардлагыг (бичгийн хэлбэрээс аман хэлбэрт) өөрчилсөн, зөөлрүүлсэн тохиолдолд ч талууд бичгээр гэрээ байгуулах боломжтой ба харин одоогийн эрх зүйн орчны хүрээнд бичгээр байгуулах хэлбэрийн шаардлага тавигдаж байгаа хэлцлийг амаар байгуулах боломжгүй байгаа юм. Иймээс дээр дурдсан дэмжээгүй бизнес эрхлэгчдийн хувьд хэлцлийг бичгээр байгуулах хэлбэрийн шаардлагыг өөрчилсөн ч өөрийн хүсэл зоригийн хүрээнд бичгээр байгуулах магадлалтай гэж тайлбарлаж болно. Энэ үр дүн нь Монголын нөхцөлд хэлцлийн талууд бие биедээ итгэх итгэл буурсантай тодорхой хэмжээгээр шууд хамааралтай юм (График 18 үзнэ үү). Хэлцлийг аман хэлбэрээр байгуулаад жич бичгийн хэлбэрт оруулна гэдгийг дэмжсэн 28 хувь ч мөн адил итгэлцэл буурсан нөхцөл байдалтай холбоотой хариулт бөгөөд сүүлд бичгийн хэлбэрт оруулж байгаа нь тохиролцоо, хүсэл зоригийн агуулгын талаар маргаан үүсэхээс сэргийлэх зэрэг нотлох баримтын ач холбогдлыг бодолцсонтой холбоотой гэж үзэхээр байна.

Харин олон жилийн турш хамтарсан бизнес эрхлэгчтэй аман хэлбэрээр гэрээ байгуулах зохицуулалтыг дэмжинэ гэсэн 14 хувь, эрсдэл багатай гэж үзвэл дэмжинэ гэсэн 17 хувийн судалгаанд оролцогчид эрх зүйн зохицуулалтын хувилбар талаас хариулт өгсөн, шаардлагатай үед бичгээр байгуулахыг сонгоно, бусад үед аман байдлаар хэлцлээ хүчин төгөлдөр байх боломжийг дэмжсэн гэж үзэж болох юм. Гэхдээ санал асуулгын энэ асуултын хувьд зөвхөн бичгээр байх хэлбэрийн шаардлага зарим гэрээнд тавих уу, эсхүл амаар хэлцэл хийхийг хуулиар зөвшөөрөх үү гэдэг хүрээнд асуусан асуулт бөгөөд нотариат, улсын бүртгэлийн асуудлыг хөндөж асуугаагүй болно.

Эсрэгээрээ ярилцлагын судалгааны хүрээнд бизнес эрхлэгчид хэлцлийн аман, бичгийн хэлбэрийн шаардлагаас илүүтэй гэрээг нотариатаар гэрчлүүлэх, цахим хэлцлийн асуудалд анхаарал хандуулсан байдаг тул үүнийг мөн бодлого боловсруулагчид анхаарах нь зүйтэй байна.

4.6. Хэлцлийн зардлын хуваарилалт

Иргэний эрх зүй дэх гэрээтэй холбоотой зардлыг гэрээ байгуулах зардал болон үүрэг гүйцэтгэх зардал гэж 2 хувааж авч үздэг. Гэрээ байгуулах болон гэрээний үүргийн гүйцэтгэлд гарах зардлыг талуудыг хэн нь хариуцах нь чухал ач холбогдолтой юм. Гэрээ байгуулах зардлын талаар Иргэний хуульд тодорхой зохицуулалт байхгүй. Ийнхүү хуулийн зохицуулалтгүй байдлын улмаас гэрээ байгуулах зардлыг хэн, хэрхэн хариуцах асуудал шүүхийн практикт маргаан дагуулсан асуудал юм. Энэ асуудал тодоор илэрсэн маргаан бол банкуудын

зээл олгохдоо авч буй шимтгэл, хураамж гэх төлбөрийг давхардуулж авдаг, шимтгэлийг бодит зардалтай уялдуулаагүй буюу өндрөөр тооцдог тухай маргаан юм.

Иймд хуульд гэрээний зардлыг хэрхэн хувиарлах талаар талууд чөлөөтэй өөрөөр тохиролцож болох дифолт зохицуулалт бий болгох нь маргаанаас урьдчилан сэргийлэх, мөн бизнес эрхлэгчийн ашгийн төлөөх үйл ажиллагааг дэмжих, эрх зүйн харилцааг илүү тодорхой болгох ач холбогдолтой. Тиймээс бизнес эрхлэгчдийн дунд хэлцлийн зардлын хуваарилалттай холбоотой асуултад хэрхэн хариулсныг доорх хүснэгтээр харуулья.

Хүснэгт 6. Хэлцлийн зардлын хуваарилалт

№	Зохицуулалт	Тийм	Үгүй	Зарим даа	Мэдэхгүй
1	Бизнес эрхлэгчдийн хооронд байгуулсан гэрээнд тусгайлан тохиролцоогүй бол гэрээ байгуулахад гарах зардлыг аль тал хариуцахыг хуульд тодорхой зохицуулах шаардлагатай юу?	49.6%	8.2%	23.9%	18.3%

Хүснэгт 6-д байгаа хариултыг үзвэл судалгаан оролцогчдын 50 орчим хувь нь “Гэрээ байгуулахад гарах зардал (нотариатын хураамж, банкны шимтгэл, үнэлгээний зардал г.м.)-ыг аль тал нь хариуцахыг хуульд тодорхой зохицуулах шаардлагатай, тодорхой байсан нь зүйтэй” гэж, 23.9 хувь нь зарим тохиолдолд шаардлагатай үзжээ. Өөрөөр хэлбэл, гэрээ байгуулахтай холбоотой гардаг зардлыг талууд тусгайлан тохиролцоогүй бол хуульд заасан зарчим, эсхүл аргын хүрээнд шийдвэрлэхийг дэмжсэн байгаа бол энэ нь гэрээний төрөл, агуулга зэргээс хамаарч ялгамжтай буюу зарим гэрээнд ийм зохицуулалт байхыг дэмжинэ, зарим гэрээнд ийм зохицуулалт байхыг дэмжихгүй гэсэн хариулт гэж тайлж болох юм.

Гэхдээ энд дурдсан үр дүн нь гэрээг бизнес эрхлэгчид байгуулж буй тохиолдолд хуульд зааснаас өөрөөр тохиролцох эрх чөлөөг бүрэн хязгаарлах шаардлагатай эсэхийг авч үзээгүй ба харин стандарт нөхцлийн хувьд гэрээгээр тохиролцох орон зай байх эсэхийг бодолцох шаардлагатай.

4.7. Хуульд заасан хүүгийн талаар

Иргэний хуулийн 222-р зүйлийн 222.5 дахь хэсэгт “Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй” гэж заасан байдаг. Манай улсын шүүхийн практикт “тохирсон хүү”

гэх ойлголтыг хэрхэн ойлгох талаар талууд гэрээгээр тохиролцож “тохирсон хүү” гэж үзэх үү, эсвэл гэрээгээр тохиролцсон эсэхээс үл хамаарах хуульд заасан хүү юу гэсэн асуудал маргаан дагуулдаг хэвээр байна. Мөн хуульд заасан хүү гэж үзсэн ч тэр нь ямар агуулгатай болох талаар маргаж байна.

Гадаадын олон улсын арилжааны эрх зүйн хувьд бизнес эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах үүднээс мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд гэрээгээр тохиролцсон эсэхээс үл хамааран хуульд тоон байдлаар илэрхийлсэн эсхүл тодорхой аргачлалд заасан хэмжээгээр бизнес эрхлэгч болох үүрэг гүйцэтгүүлэгч бизнес эрхлэгч болох үүрэг гүйцэтгэгчээс хүү шаардах эрхтэй байх нь шударга ёсонд нийцнэ гэж үздэг. Энэ нь бизнес эрхлэгч мөнгөн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хугацаанд нь авсан бол аж ахуй эрхэлдэггүй этгээдтэй харьцуулахад тухайн мөнгийг ашгийн төлөөх үйл ажиллагааныхаа эргэлтэд оруулан үр шимийг хүртэх байсан нь ойлгомжтой гэдэг логикт үндэслэдэг. Иймд хуульд зааснаар хүү шаардах эрхийг автоматаар үүсдэг байх шаардлагыг судалгаанд оролцогчид хэрхэн дүгнэж байгааг доорх хүснэгтээр харуулья.


Хүснэгт 7. Хуульд заасан хүүтэй холбоотой зохицуулалтыг дэмжих эсэх

№	Зохицуулалт	Тийм	Үгүй	Зарим даа	Мэдэхгүй
1	Өртэй этгээд нь төлбөрөө хугацаанд нь төлөөгүй бол гэрээгээр тохиролцоогүй байсан ч хуульд заасан хэмжээ, эсхүл аргачлалын дагуу хүү шаардах эрхтэй байх зохицуулалт бизнес эрхлэгч Танд хэрэгтэй гэж үзэж байна уу?	38.6%	12.9%	32.2%	16.3%

Бизнес эрхлэгчид “*өртэй этгээд нь төлбөрөө хугацаандаа төлөөгүй бол гэрээгээр тохиролцоогүй байсан ч хүү шаардах эрхтэй зохицуулалт хэрэгтэй*” гэж дийлэнх нь буюу 70.8 (38.6+32.2) хувь нь үзсэн байна. Энэ нь бизнес эрхлэгчид өөрсдийн ашгийн төлөөх зорилгыг хангахын тулд гэрээгээр тохиролцоогүй байсан ч тодорхой хүү авах эрхээ баталгаажуулахыг дэмжиж байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Өөрөөр хэлбэл, талууд гэрээндээ хүү заагаагүй байсан ч хуульд заасан тодорхой хувь хэмжээнд хүү шаардах эрхтэй байх боломжийг бүрдүүлэхээс гадна нөгөө талаар талууд гэрээгээр хүүгийн түвшинг тогтоох гэрээний чөлөөт байдлын зарчмыг хязгаарлахгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Түүнчлэн доорх График 15-аас харахад хуульч болон компанийн удирдах албан тушаалд ажиллаж буй хүмүүсийн 51.6 - 66.7 хувь нь хуульд заасан хүүгийн хэмжээг бий болгох шаардлагатай гэж хариулсан. Нийт оролцогчдын дүнгээр авч үзвэл шаардлагатай, зарим тохиолдолд шаардлагатай гэж хариулсан хариултын хувь 70.8 хувьтай байгаа нь одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд бизнес эрхлэгч талуудын хүү шаардах эрхийг бүрэн дүүрэн зохицуулж чадахгүй байгааг илэрхийлж байна.

График 16. Хуульд заасан хүүтэй холбоотой зохицуулалтыг дэмжих эсэх (ажил, албан тушаалаар)



4.8. Бизнесийн гэрээ, хэлцэлд холбогдох эрх зүйн зохицуулалтын зарим асуудал

Бизнес эрхлэгчдийн хоорондын гэрээ, хэлцэлд холбогдох одоо үйлчилж байгаа эрх зүйн зохицуулалтыг сайжруулах талаар олон хариултыг зэрэг сонгож болох 9 хувилбартайгаар асуухад судалгаанд оролцогчдийн 1/3 нь буюу 29.6 хувь нь үл маргах журмаар төлбөр гаргуулах зохицуулалт, 19.1 хувь нь торгууль, алданги гэх мэт үүргийн гүйцэтгэлийг хангах арга, 17.6 хувь нь хамтран үүрэг гүйцэтгэх, барьцааны зохицуулалтыг сайжруулах шаардлагатай хэмээн хариулжээ. Харин 5.1 хувь нь одоогийн гэрээ, хэлцэлд холбогдох эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, өөрчлөх санал байхгүй, 29.9 хувь нь мэдэхгүй гэсэн байна. Харин санал болгосон хариултаас бусад асуудлыг сонгох боломжийг олгосон боловч эдгээрийг зөвхөн 1.4 хувь нь тэмдэглэсэн байна. Энд оролцогчдын өгсөн хариулт нь бизнес эрхлэгчид өөрсдийн тогтсон хандлага (дадал)-аараа бизнесээ эрхэлж ирсэнтэй холбоотой байж болохоос гадна хариултын

хувилбарууд нь эрх зүйн нарийн, тодорхой мэдлэг шаардсан асуудал учир хариулахад төвөгтэй байсан болов уу. Гэхдээ одоогийн эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн хувь маш бага буюу 5.1 хувь байгаа нь эрх зүйн зохицуулалтын өнөөгийн орчингийн талаар бизнес эрхлэгчид төдийлөн сэтгэл хангалуун бус байгаа, эрх зүйн орчинтой холбоотой ямар нэг зүйл болохгүй байгаа гэсэн ерөнхий уур амьсгал бизнес эрхлэгчдийн дунд байгаа болохыг илэрхийлж байна.

График 17. Бизнес эрхлэгч хоорондын гэрээ, хэлцэлд холбогдох эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай асуудал



4.9. Бизнесийн гэрээг байгуулсанд тооцохтой холбоотой асуудал

Судалгаанд оролцогчдоос бизнесийн гэрээ, хэлцлийг байгуулах явцыг түргэн шуурхай болгоход одоогийн эрх зүйн орчныг хэрхэн сайжруулах тухай саналыг олон хариулт зэрэг сонгож болохоор асуухад (Бизнесийн гэрээ, хэлцэл байгуулах явцыг түргэн шуурхай болгох үүднээс одоогийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай ямар асуудал байна вэ?) 36.9 хувь нь “гэрээг заавал бичгээр байгуулах, нотариат, улсын бүртгэлд бүртгүүлэх зэрэг хэлбэрийн шаардлагыг уян хатан болгох”, 27.6 хувь нь “цахимаар гэрээ, хэлцэл байгуулах зохицуулалтыг сайжруулах”, 26.9 хувь нь “бизнес эрхлэгчдийн хооронд байгуулагдах гэрээний стандарт нөхцөлийг бий болгох” зэрэг үндсэн саналуудыг дэмжсэн хариулт өгсөн байна. Сайжруулах тухайд санал болгосон хариултаас огт дэмжигдээгүй хариулт байхгүй бөгөөд харин мэдэхгүй гэсэн хариулт 24.2 хувь эзэлж байгаа нь зарим судалгаанд оролцогчдын хувьд асуулт нь мэргэжлийн мэдлэг шаардагдаж байгаатай холбоотой байж болох юм. Мөн санал болгосон сайжруулах 6 хувилбарт хамаарахгүй бусад гэсэн хариулт бага буюу 1.5 хувь байгаа нь сайжруулах шаардлагатай бүх асуудлын тухайд хариулт өгсөн байна гэж үзэж болох юм. Бизнесийн хэлцлийн түргэн, шуурхай шинжийг нэмэгдүүлэх тухайд өнөөгийн эрх зүйн орчин хангалттай, өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн хувь

харьцангуй бага буюу 6.6 хувь байгаа нь энэ асуудлыг хууль тогтоогч, бодлого боловсруулагчид анхаарах нь зүйтэй болохыг харуулж байна.

График 18. Бизнесийн гэрээ, хэлцлийг байгуулсанд тооцохтой холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоход анхаарах асуудал



Шигтгээ 4. “МБМБ” ТББ-ын захиралтай хийсэн ярилцлагаас

... Гэрээ хэлцлийг холбогдох байгууллага баталгаажуулах нь өөрөө зохистой харилцаа байх л даа гэхдээ өнөөгийн нөхцөлд заавал биеэчлэн байх, эх хувь баримт бичгийг дахин давхардуулан нотариатаар баталгаажуулах зэрэг асуудлуудыг цахим (онлайн) бүртгэлээр шүүн баталгаажуулах зэрэг цаг хугацаа хэмнэсэн шийдлүүд олон байх бололцоотой.

Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын үед орон зай, цаг хугацаанаас үл хамааран банкны үйлчилгээг харилцагчдад зайнаас тасралтгүй үзүүлэх ёстой. Гэтэл зайнаас гэрээ байгуулахтай холбоотой Монгол Улсын эрх зүйн зохицуулалт дутмаг байгаа нь асуудлыг шийдвэрлэхэд бэрхшээл учруулж байна гэж үзэж болно.

Шигтгээ 5. “Зайнаас гэрээ байгуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал: Банкны жишээн дээр” нийтлэлээс

... Цахим гарын үсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь хэсэгт тоон гарын үсэг нь цахим гарын үсгийн зөвхөн нэг төрөл болохыг тодорхойлсон боловч тоон гарын үсгээс бусад цахим гарын үсгийн төрлүүдийг хэрэглэх, ийнхүү хэрэглэсэн тохиолдолд зайнаас байгуулсан гэрээг хүчин төгөлдөр гэж үзэх эрх зүйн зохицуулалт хууль тогтоомжид хараахан зохицуулагдаагүй байна. Энэхүү эрх зүйн зохицуулалт дутмаг байдал нь банкны үйлчилгээг харилцагчид орон зай, цаг хугацаанаас үл хамааран түргэн шуурхай, тасралтгүй үзүүлэх, цаг хугацаа, зардал хэмнэх зэрэг олон чухал давуу талыг бий болгоход бэрхшээл болж байна.

Иргэний хуулийн 42 дугаар зүйлийн 42¹.1-т “хуульд зааснаар бүртгүүлэх, нотариатаар гэрчлүүлбэл зохих болон бичгээр хийхээр заасан хэлцлийг цахим хэлбэрээр хийж болно”, 42².2-т “хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр хийх хэлцэл нь хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурж илгээснийг гэрээний нөгөө тал нь хүлээн зөвшөөрч тоон гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно”, 42.10-т “энэ хуулийн 42¹.1-д зааснаас бусад тохиолдолд бичгээр хийх хуулийн шаардлагыг хангаагүй хэлцэл хүчин төгөлдөр бус байх бөгөөд энэ тохиолдолд талууд хэлцлээр авсан бүх зүйлээ харилцан буцааж өгнө” гэж заасан. Хуулийн дээрх зохицуулалтаас үзэхэд, банкны үйлчилгээг зайнаас үзүүлэхдээ гэрээний хүчин төгөлдөр байдлыг хангах цорын ганц боломж нь талууд тоон гарын үсэг ашиглах явдал юм. Энэхүү шаардлагыг хангаагүй нөхцөлд хэлцлийг анхнаасаа хүчин төгөлдөр бусад тооцож, хэлцлээр авсан зүйлээ харилцан буцаах, банк, хүү, нэмэгдүүлсэн хүү шаардах эрхээ алдах үр дагавар үүсч болохоор байна. Мөн зайнаас байгуулах гэрээний хүчин төгөлдөр байдлыг хангах боломж болсон тоон гарын үсгийн хүртээмж хангалтгүй байгаа энэ нөхцөлд арилжааны банкууд дотооддоо зохицуулалт хийх замаар шийдвэрлэж байна.

Тиймээс холбогдох хууль тогтоомжид эрх зүйн орчны сайжруулалт хийж, банкны бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэхээр цахимаар гэрээ хүчин төгөлдөр болох хэлбэрүүдийг банкны үйлчилгээний онцлогт нийцүүлэн хуульчлах шаардлага өнөө үед үүсээд байна.

Санал асуулгын дүн болон ярилцлагын дүнг үндэслэвэл бизнес хийх хурдын асуудалд бизнес эрхлэгчид ихээхэн анхаарал хандуулдаг, энэ тухайд эрх зүйн орчинг илүү боловсронгуй болгох, өөрчлөх шаардлага байгаа нь харагдаж байна.

4.10. Тулгамдаж байгаа асуудлаа бизнес эрхлэгчид эрэмбэлсэн байдал, агуулга

Судалгаанд оролцогчдоос бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлуудыг 13 бодомжид хуваарилан тэдгээрт 1-5 хүртэлх оноо (Бүрэн санал нийлж байна – 5 оноо, Ер нь санал нийлж байна – 4 оноо, Дунд зэрэг – 3 оноо, Санал нийлэхгүй байна – 2 оноо, Огт санал нийлэхгүй байна – 1 оноо) өгөх байдлаар дүгнүүлсэн болно. Ингэхдээ тухайн бодомжид өгсөн нийт онооны нийлбэрийг санал өгсөн хүний тоонд хуваан дундажийг гаргасан болно. Санал асуулгыг нийт 604 бизнес эрхлэгч бүрэн бөглөсөн, гэхдээ тэдгээрийн 19.3% - 28.4% нь мэдэхгүй хэмээн хариулсан гэж үзвэл судалгаанд оролцогчид эдгээр 13 бодомжийг үндсэнд нь дэмжсэн буюу 3.39 – 3.75 оноо өгсөн байна.

Хүснэгт 8. Бизнес эрхлэгчдийн хувьд тулгамдаж байгаа асуудлыг эрэмбэлсэн байдал

Эрэмбэ	Бодомж	Оноо	Мэдэхгүй
1	Хувиараа бизнес эрхлэгчийг бүртгэхгүй байгаа байдал болон санхүүгийн тайлан тооцоо хөтөлдөггүй явдал нь хэлцлийн найдвартай, баталгаат байдлыг хангаж чадахгүй, улмаар компани, нөхөрлөл нь хувиараа бизнес эрхлэгч иргэнтэй хэлцэл хийхэд хүндрэл үүсгэж байна.	3.75	19.3%
2	Өөрийн бизнесээ бүхэлд нь хариуцуулах эсхүл тодорхой хэсгийг нь удирдуулах, төлөөлөх эрхийг бусдад хэрхэн олгох, түүнтэй холбоотой үр дагаврын талаарх зохицуулалтыг сайжруулах шаардлагатай.	3.75	20.5%
3	Хуульд нэрлэн заасан гэрээний зохицуулалтыг бизнес эрхлэгчийн ашиг сонирхлыг хангах үүднээс системчилж, бие даасан тусгай хууль болгон батлах шаардлагатай байна.	3.75	26.6%
4	Нэг удаагийн шинжтэй буюу дахин давтан хийгддэггүй гэрээний харилцааг зохицуулсан шинжтэй зохицуулалт нь байнгын бизнесийн харилцаатай байдаг этгээдүүдийн хоорондын харилцааны зохицуулалтаас ялгаатай байх нь зохимжтой.	3.67	28.4%
5	Бизнес эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах талаарх зохицуулалт тодорхойгүй байгаагийн улмаас бизнесийн үйл ажиллагаанд хүндрэл, тодорхойгүй байдал үүсгэж байна.	3.66	23.1%
6	Бизнес эрхлэгчийн мэдээлэл буруу бүртгэгдсэнээс үүсэх үр дагаврыг буруутай этгээдэд хүлээлгэх, хэлцлийн нөгөө талын эрх ашгийг хамгаалах эрх	3.66	24.5%

	зүйн орчин бүрдээгүй.		
7	Төлөөлөх бүрэн эрхгүй этгээдтэй хэлцэл хийснээс, хэлцэл нь хүчингүй болж хэлцлийн нөгөө талыг хохироох нөхцөл үүсэж байна.	3.62	21.5%
8	Бизнес эрхлэгч гэдгийг тодорхойлсон зохицуулалт байхгүйн улмаас бизнесийн үйл ажиллагаа болон иргэд хоорондын ахуйн шинжтэй үйл ажиллагааг хооронд нь ялгах боломжгүйд хүрч байна.	3.55	22.4%
9	Бизнес эрхлэгч хоорондын болон иргэд хоорондын гэрээнээс үүсэх маргааны хөөн хэлэлцэх хугацаа ижил байгаагаас бизнесийн харилцааны түргэн шуурхай, баталгаат байдалд сөрөг нөлөө үзүүлнэ.	3.52	25.9%
10	Зарим хэлцлийг заавал бичгээр байгуулах, нотариатаар гэрчлүүлэх гэх мэт хуульд заасан нь бизнес эрхлэгч хооронд хийгдэх хэлцлийн уян хатан, түргэн шуурхай байдалд саад болж байна.	3.51	19.7%
11	Хуулийн этгээдийг төлөөлөх бүрэн эрхийн хэмжээ, хязгаарын талаар хуульд товч зохицуулсан нь хэлцлийн нөгөө талыг төлөөлөх этгээдийн бүрэн эрхийн талаар мэдэх, урьдчилан таамаглах, эрсдэлийг тооцоолоход хүндрэлтэй байдлыг үүсгэж байна.	3.48	27.4%
12	Бизнес эрхлэгчийн нэрийн талаарх зохицуулалт тодорхойгүйгээс бизнесийн нэрийг бусдад ашиглуулах, бизнесээ түрээслэх замаар ашиг олох боломжгүй байна.	3.47	24.7%
13	Бизнесийн байгууллагад ажиллаж байсан ажилтан, албан тушаалтан эсхүл тодорхой эрхээ бусдад шилжүүлсэн аж ахуйн нэгжид адил төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхлэхгүй байх буюу өрсөлдөхгүй байх үүргийг хуулиар хүлээлгэх шаардлагатай.	3.39	23.7%

Арга зүйн хувьд бодомжийн дарааллыг асуулгын хуудаст дараалуулан жагсааж бичсэн бөгөөд Хүснэгт 8-д байгаа дараалал нь санал асуулгад оролцогчийн өгсөн онооны дундажаар жагсааж, эрэмбэлсэн болно. Энэхүү дарааллыг анхаарвал дараахь дүгнэлт хийж болохоор байна:

1. Хувиараа бизнес эрхлэгчтэй холбоотой анхаарал татсан асуудал эрэмбийн хувьд хамгийн эхэнд тавигдаж байна. Санал асуулгын судалгаанд оролцогч 604 бизнес эрхлэгчийн 356 буюу 60.1 хувь нь өөрийгөө хувиараа бизнес эрхлэгч гэж тодорхойлсныг судалгаанд оролцогчдын мэдээллийн хэсгээс харж болно. Ийм өндөр хэмжээнд идэвхитэй оролцсон учраас өөрсдийн тулгардаг

асуудлыг шийдвэрлүүлэх талаар санал өгсөн байх магадлалтай ба энэ асуудлыг хууль тогтоогч, бодлого боловсруулагчид анхаарах хэрэгтэй нь харагдаж байна.

Монгол Улсад бизнес эрхлэгчдийн хувьд хувиараа бизнес эрхлэгчид нь бүртгэлтэй эсэхээс үл хамааран тооны хувьд ихээхэн олон байдаг. Энэ утгаараа хувиараа бизнес эрхлэгчийн бизнес (арилжаа)-ийн үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх нь нийгмийн болоод эдийн засгийн хувьд ихээхэн ач холбогдолтой. Энэ бодомжийн хувьд хувиараа бизнес эрхлэгчийг бүртгэхгүй байгаа байдал болон санхүүгийн тайлан тооцоо хөтөлдөггүй явдал нь хэлцлийн найдвартай, баталгаат байдлыг хангаж чадахгүй, улмаар компани, нөхөрлөл нь хувиараа бизнес эрхлэгч иргэнтэй хэлцэл хийхэд хүндрэл үүсгэж байгаа тул өөрчлөх шаардлагатай гэж дүгнэсэн. Үүний шалтгаан нь арилжааны эрх зүйн зарчим болох хэлцлийн найдвартай, баталгаат байдлын зарчим нь бүртгэлийн тогтолцоогоор дамжин хэрэгжих замаар нөгөө талын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалдагт оршдог бол хувиараа бизнес эрхлэгчийн бүртгэлийн тогтолцоо байхгүй нь тус зарчим бүрэн хангагдах боломжгүй болгодог.

Шигтгээ 6. “Д И” ХХК-ийн захиралтай хийсэн ярилцлагаас

... Хувиараа бизнес эрхлэгчийн ямар нэгэн бүртгэлийн тогтолцоо байдаггүй тул хэлцэл найдвартай баталгаатай байх зарчим зарим тохиолдолд алдагдах магадлалтай. Бизнес эрхлэгчийн бизнесийн баталгаат байдал, тэдгээрийн хэлцлийн хурдан шуурхай, найдвартай байдлыг хангахад чиглэгддэг боловч одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд зөвхөн хуулийн этгээдийн хувьд дээрх зорилго хангагдах боломжтой байна.

Нөгөө талаар жижиг худалдаа эрхлэх зэргээр бизнес (арилжаа)-ийн үйл ажиллагаа явуулдаг этгээдийн хувьд санхүүгийн баримт өгөх бололцоогүй, хувиараа бизнес эрхлэгчийг бүртгэхгүй, санхүүгийн тайлан тооцоо хөтлөхгүй байгаа байдал, хувь хүнтэй бизнес (арилжаа)-ийн харилцаанд оролцоход хуулийн этгээдүүд төдийлөн сонирхолгүй (НӨАТ өгөхгүй, санхүүгийн баримтыг татварын алба, нийгмийн даатгалын алба баримт гэж үзэхгүй байх) байдаг нөхцөл байдал ярилцлагын судалгаа хийх явцад илэрч байсан болно. Энэ нь томоохон аж ахуйн нэгж, байгууллагуудтай бизнесийн харилцаа тогтоох, бизнесээ өргөжүүлэх, нэмэлт санхүүжилт татах зэрэгт саад болохын зэрэгцээ хувиараа бизнес эрхлэгчтэй бусад бизнесийн байгууллага хэлцэл хийхээс зайлсхийх, хуурамч баримт бүрдүүлэхэд хүргэж байж болзошгүй байна. Өөрөөр хэлбэл, банк, санхүүгийн байгууллагаас зээл авахад шаардлагатай бизнесийн үйл ажиллагааны орлогыг нотлох санхүүгийн баримт үйлддэггүй, НӨАТ-ын баримт өгдөггүй нөхцөл байдал байсаар

байна. Түүнчлэн албан ёсны бизнес эрхлэгчийн бүртгэлгүйгээс аливаа гэнэтийн аюул, гамшигт өртөхөд түүнээс урьдчилан сэргийлэх, хохирлыг нөхөн төлөх бүрэн хэмжээний даатгалын тогтолцоонд хамрагдахгүй, бизнесийн үйл ажиллагаа доголдсон, тасалдсан, зогссон тохиолдолд ч төрөөс үзүүлж буй хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдаж чадахгүй байх нөхцөлийг бий болгож байна.

2. Бизнес эрхлэгчийн чухал хэмээн 2 дугаарт эрэмбэлсэн асуудал болох бусдаар өөрийн бизнесээ удирдуулах, төлөөлүүлэх, бусдад хариуцуулах явдал нь санал асуулгын болон ярилцлагын судалгааны явцад байнга хөндөгдөж байсан асуудал юм. Бизнес өргөжин тэлэх тусам өмчийн эзэд буюу өмчлөгчид нь бусдын туслалцаа авах зайлшгүй шаардлага гардаг. Гэтэл нэг талаас бизнесийн салбар дахь итгэлцэл буурсан байдаг, нөгөө талаас бусдад бизнесийн зарим хэсгээ хариуцуулах, зарим үйлдлийг өөрийн өмнөөс хийлгэх шаардлага гарч байна. Энэ хүрээнд одоогийн эрх зүйн орчин хангалттай бус байна гэдэгт санал асуулгад оролцогчдын мэдэгдэхүйц хэсэг санал нийлж байгаа тул эрх зүйн зохицуулалтыг анхаарч, дахин үнэлж цэгнэх, бусад улсын бизнесийн практиктай харьцуулан авч үзэх хэрэгтэй болох нь харагдаж байна.

3. Хуульд нэрлэн заасан гэрээний зохицуулалтыг бизнес эрхлэгчийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс системчилж, бие даасан тусгай хууль болгон батлах шаардлагатай байна гэдэг бодомжид хариулсан хүмүүсийн дийлэнх нь санал нийлсэн байна. Бизнес эрхлэгчийн байгуулдаг гэрээний эрх зүйн зохицуулалтыг агуулсан бие даасан хууль гарахыг бизнес эрхлэгчид дэмжих хандлагатай байна гэж дүгнэж болох юм. Өөрөөр хэлбэл, Арилжааны хууль боловсруулан батлахад тухайн хууль голчлон үйлчлэх субъектүүд эрс эсэргүүцсэн орчин, нөхцөл харьцангуй бага байх магадлалтай, харин зохицуулалтын хүрээ, хэм хэмжээний агуулга зөвөөр хийгдсэн тохиолдолд дэмжихээр байгаа гэж үзлээ.

Гэхдээ тэдгээрийн нилээд хэсэг (26.6%) мэдэхгүй хэмээн хариулсан нь энэ асуудал санал асуулгад оролцогчдын нилээд хэсэгт санал өгөхөд хүндрэлтэй, одоогийн нөхцөл байдлыг үнэлж дүгнэхэд нарийн мэдлэг шаардлагатай байгаатай холбоотой юм. Магадгүй эдгээрийн ихэнх хэсэг нь хувиараа бизнес эрхлэгч байсан байх магадлалтай юм.

4. Нэг удаагийн шинжтэй буюу дахин давтан хийгддэггүй гэрээний харилцааг зохицуулсан зохицуулалт нь байнгын бизнесийн харилцаатай байдаг этгээдүүдийн хоорондын харилцааны зохицуулалтаас ялгаатай байх нь зохимжтой гэсэн бодомжийг санал асуулгад оролцогчид харьцангуй дэмжсэн гэж үзлээ. Энэ нь нэг талаас бизнес эрхлэгч хооронд байгуулдаг хэлцлийн эрх зүйн орчин нь бизнес эрхлэгч бус иргэд хоорондын хэлцлээс ялгаатай байх ёстойг, нөгөө талаас байнгын харилцаатай байдаг бизнес эрхлэгч хоорондоо байгуулах гэрээнд холбогдох эрх зүйн орчин нь анх удаа буюу байнгын бус харилцааны хүрээнд

бизнес эрхлэгч хооронд байгуулах гэрээнд хамаарахгүй байхыг дэмжсэн байна. Гэхдээ өмнөхийн адил мэдэхгүй хэмээн хариулсан оролцогч их (28.4%) байгаа тул үүнийг ялгамжтай авч үзэх нь зүйтэй байна. Тухайлбал, хувиараа бизнес эрхлэгч иргэд хоорондын харилцаанд энэ нь заавал ялгамжтай байх шаардлагагүй болохыг үгүйсгэхгүй юм.

5. “Бизнес эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах талаарх зохицуулалт тодорхойгүй байгаагийн улмаас бизнесийн үйл ажиллагаанд хүндрэл, тодорхойгүй байдал үүсгэж байна” гэсэн бодомж нь харьцангуй ерөнхий шинжтэй ба бодомжийн гол агуулга нь ашгийн төлөөх зорилгыг эрх зүйн орчин дэмжиж байгаа эсэхэд холбогдох юм. Энэ үүднээс авч үзвэл, бизнес эрхлэгчид холбогдох эрх зүйн орчин нь түүний бизнесийн үйл ажиллагаанд холбогдох ашгийн төлөөх зорилгыг дэмжиж байгаа эсэхэд зарим талаар эргэлзээ бизнес эрхлэгчдийн дунд байхыг үгүйсгэхгүй байна.

6. Энэ бодомж болох бизнес эрхлэгчийн мэдээлэл буруу бүртгэгдсэнээс үүсэх үр дагаврыг буруутай этгээдэд хүлээлгэх, хэлцлийн нөгөө талын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин бүрдээгүйтэй холбоотой асуудал нь бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал байна. Тухайлбал, хуулийн этгээдийн мэдээлэл буруу бүртгэгдсэнээс үүдэн бүртгэлд итгэж хэлцэл хийсэн гуравдагч этгээдийг хэрхэн хамгаалах, бүртгэл хүчингүй болсноос өмнөх хэлцлийн үр дагаврыг хэрхэн шийдвэрлэх, бүртгэлийн талаар мэдээгүй буюу мэдэх боломжгүй нөхцөлд гэрээ хэлцэл хийсэн зэрэг асуудлыг зөвхөн Иргэний хуульд нийцүүлэн шийдвэрлэх нь бизнесийн үйл ажиллагааг түргэн шуурхай явагдахгүй байх, маргаан үүсгэх, гэрээ хэлцлийн тогтворгүй байдлыг бий болгож зардлыг нэмэгдүүлэх үр дагаварт хүргэж байна. Одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд компанийн хувьцаа эзэмшигчийн эзэмшлийн хувьд бүртгэлийн байгууллагад буруу бүртгэгдсэний улмаас тухайн хувьцаа эзэмшигч нь гуравдагч этгээдийн хувьд шийдвэр гаргах эрхтэй гэж ойлгогдсон тохиолдолд тус бүртгэлд итгэж хэлцэл хийсэн гуравдагч этгээдийн хэлцэл хүчинтэй эсэх маргаан үүсдэг. Энэ тохиолдолд бүртгэл буруу хийгдсэн үндэслэлээр бүртгэлийг хүчингүйд тооцох нь түүнд үндэслэсэн хэлцэл хүчингүй болох нөхцөл болдог.

Түүнчлэн, Компанийн тухай хуулийн 70 дугаар зүйлд “хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргах”-аар зохицуулсан бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлаар их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрсөн шийдвэр гаргаж, гуравдагч этгээдтэй хэлцэл хийсэн тохиолдолд өөр нэг хувьцаа эзэмшигч тухайн хурлын зар хүргэхдээ хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр хурлыг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргадаг. Гэтэл шүүхэд тухайн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчингүйд тооцвол тухайн хурлаас гарсан шийдвэр нь хүчингүйд тооцогдох практик байна. Гэтэл өмнөх шийдвэр хүчинтэй гэж итгэж

хэлцэл хийсэн гуравдагч этгээдийн хувьд Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-д заасан хууль зөрчсөн хэлцэл, 56.1.10-т заасан “хүчин төгөлдөр бус хэлцлийг үндэслэж хийсэн бусад хэлцэл хүчин төгөлдөр бус байх” гэж заасны дагуу сөрөг үр дагавар үүсдэг.

Эдгээр асуудал нь зөвхөн бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хяналтын чиг үүргээс илүүтэй Арилжааны эрх зүй дэх хэлцлийн баталгаатай байдал, шударга гуравдагч этгээдийн хэлцэлд итгэх итгэлийг хамгаалах зарчимд харшлах үндэслэл болдог. Иймд бизнес эрхлэгчийн бүртгэлээр дамжин бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгосноор бизнес эрхлэгчдийн хэлцэл баталгаат, түргэн шуурхай, найдвартай хийгдэх боломжийг олгодог ач холбогдолтой болохыг бизнес эрхлэгчид дэмжсэн байна.

7. Одоогийн эрх зүйн орчны хувьд бизнесийн харилцаа хэдий ч төлөөлөх бүрэн эрхгүй этгээд хэмээн тооцогдож, улмаар тэдгээрийн төлөөлөн хийсэн хэлцэл нь хүчингүй болж хэлцлийн нөгөө талыг хохироох нөхцөл үүсэж байна хэмээн үзсэн байна. Өөрөөр хэлбэл, бизнесийн харилцааны хүрээнд гарч байгаа төлөөлөл нь хэрэглэгч иргэд хооронд үүсдэг төлөөллийн харилцаанаас эрх зүйн зохицуулалтын хувьд зарим талаар дэлгэрэнгүй, эсхүл нарийвчлагдсан, өөр байх боломжийг бизнес эрхлэгчид үгүйсгэхгүй байна. Мөн ийм тохиолдлоос үүдэн хэлцлийн нөгөө тал хохирох боломжтой болохыг бизнес эрхлэгчид хүлээн зөвшөөрсөн, эсхүл бодит тохиолдол гарсныг мэдсэний үндсэн дээр хариулсан байх боломжтой юм.

8. Энэ бодомжийн хувьд бизнес эрхлэгч гэдгийг тодорхойлсон зохицуулалт байхгүйн улмаас бизнес эрхлэгчийн онцлогт тохирсон эрх зүйн орчин бий болоход томъёоллын хувьд хүндрэлтэй, иргэний бизнесийн үйл ажиллагаа болон иргэд хоорондын ахуйн шинжтэй үйл ажиллагааг хооронд нь ялгах боломжгүйд хүрч байгаа юм. Магадгүй энэхүү асуудал бизнес эрхлэгчдийн онцлогт тохирсон тусгайлсан эрх зүйн зохицуулалт шаардагдах үндсэн асуудал гэж хэлж болно. Тухайлбал, Монгол Улсын Иргэний хуульд “аж ахуйн үйл ажиллагаа” гэх нэр томъёо 8 удаа, “аж ахуйн зориулалт” гэх нэр томъёо 15 удаа удаа, “аж ахуйн” гэх нэр томъёо 33 удаа давтагдан хэрэглэгджээ. Энэ нь одоо хэрэгжиж буй Иргэний хуулийн хүрээнд аж ахуйн үйл ажиллагааны онцлогт нийцсэн зарим хэм хэмжээг бий болгосныг харуулдаг. Өөрөөр хэлбэл, хувийн эрх зүйн ердийн харилцааг зохицуулах нийтлэг зохицуулалт болон аж ахуйн харилцааг зохицуулах тусгай зохицуулалт Иргэний хуульд зэрэгцэн оршиж байгаа боловч бизнес эрхлэгч гэж хэнийг хэлэх, ямар шалгуураар тогтоох зэрэг нь тодорхойгүйгээс Иргэний хууль дахь дээрх зохицуулалтыг тохируулан хэрэглэхэд хүндрэлтэй байдаг. Жишээлбэл, Иргэний хуулиар аливаа этгээд бусдаас зээл авах, бусдын мөнгийг хадгалж болох тул зээл авах, мөнгө хадгалж хүү амлах хэлцлийг бизнесийн үйл ажиллагаа болгон

хийж буй байдлыг ердийн тохиолдлоос ялгах нийтлэг зохицуулалт Иргэний хуульд байхгүй байгаа нь юуг бизнесийн үйл ажиллагаа ба бизнес эрхлэгч гэж үзэх талаар тодорхойгүй, ойлгомжгүй байдлыг бий болгож байна. Үүний үр дүнд банк, банк бус санхүүгийн байгууллага нь тодорхой шалгуурт үндэслэн тусгай зөвшөөрөл авч санхүүгийн үйлчилгээ явуулж байхад нөгөө талд Иргэний хуульд заасан зээлийн гэрээ нэрийн дор ямар ч зөвшөөрөл, хараа хяналтгүй бизнесийн үйл ажиллагаа явуулж буй тохиолдол байсаар байна.

9. “Бизнес эрхлэгч хоорондын болон иргэд хоорондын гэрээнээс үүсэх маргааны хөөн хэлэлцэх хугацаа ижил байгаагаас бизнесийн харилцааны түргэн шуурхай, баталгаат байдалд сөрөг нөлөө үзүүлнэ” гэсэн бодомжийг мөн ялгаагүй дэмжсэн гэж үзэж болно. Хариултаас үзэхэд бизнес эрхлэгчид хөөн хэлэлцэх хугацаа нь бизнесийн хэлцэл, хэрэглэгчийн гэрээний хувьд ялгамжтай байхыг, хэрэв ялгамжтай байхгүй бол бизнесийн харилцааны түргэн шуурхай, баталгаат байдалд сөрөгөөр нөлөөлөхийг аль алиныг зөвшөөрч байна. Гэхдээ мэдэхгүй хэмээн хариулсан хувь харьцангуй өндөр (25.9%) байгаа нь хөөн хэлэлцэх хугацааны асуудал харьцангуй нарийн мэдлэг шаарддагтай холбоотой юм. Энэ нь асуулгын бусад хэсэгт хөөн хэлэлцэх хугацааны талаар асуусан хэсэгтэй нийцэлтэй байна.

10. “Зарим хэлцлийг заавал бичгээр байгуулах, нотариатаар гэрчлүүлэх гэх мэт хуульд заасан нь бизнес эрхлэгч хооронд хийгдэх хэлцлийн уян хатан, түргэн шуурхай байдалд саад болж байна” гэсэн хариултыг дэмжсэн байх бөгөөд харин мэдэхгүй хэмээн хариулсан хувь бусадтай харьцуулахад харьцангуй бага байгаа юм. Энэ асуудал асуулгын бусад хэсэгт мөн адил хөндөгдсөн ба хариулт мөн адил холбогдох эрх зүйн зохицуулалтыг анхаарах шаардлагатай гэж үзсэн байсан нь энэхүү хариутай нийцэлтэй байна.

11. “Хуулийн этгээдийг төлөөлөх бүрэн эрхийн хэмжээ, хязгаарын талаар хуульд товч зохицуулсан нь хэлцлийн нөгөө талыг төлөөлөх этгээдийн бүрэн эрхийн талаар мэдэх, урьдчилан таамаглах, эрсдлийг тооцоолоход хүндрэлтэй байдлыг үүсгэж байна” гэснийг мөн адил дэмжсэн байна. Энэ нь 2 дугаарт эрэмбэлэгдсэн бодомжтой холбоотой юм.

12. Энэ бодомжийн хувьд бизнес эрхлэгчийн нэрийн талаарх зохицуулалт тодорхойгүйгээс бизнесийн нэрийг бусдад ашиглуулах, бизнесээ түрээслэх замаар ашиг олох боломжгүй байгаа явдал юм. Өөрөөр хэлбэл бизнес эрхлэгчийн нэр буюу арилжааны нэр нь эдийн засгийн үр өгөөж бий болгодог утгаараа эд хөрөнгийн эрхэд тооцогдож түүнийг өвлүүлэх, бэлэглэх, шилжүүлэх, бусад этгээдийн эрх зөрчсөн үйлдлээс хамгаалах зэрэг эрх зүйн хамгаалалт шаардлагатай болдог. Түүнчлэн бизнесийн хамтрагч болох нөгөө талын хувьд

арилжааны нэрэнд төөрөгдөхгүй, түүнээс ямар нэгэн хохирол хүлээхгүй байх зэрэг шаардлагын үүднээс эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах хэрэгцээ бий болгохоос гадна аж ахуй эрхлэгчийг нэрлэх, танин мэдэх, бараа бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох, мэдээллийг түгээх, ялгаатай байдлыг бий болгох, хариуцлага хүлээх эрх зүйн үр дагаврыг үүсгэх зорилготой боловч энэ асуудал зохицуулалтгүй байгаа болохыг илэрхийлж байна. Энд өгсөн хариулт нь санал асуулгын бусад хэсэгт энэ талаар хариулсан байдалтай зөрчилдөхгүй байна.

13. Санал асуулгын бусад хэсэгт үл өрсөлдөх үүргийг хуулиар хязгаарлах, зохицуулах асуудлыг хөндсөн ба үүнийг зохицуулахыг дэмжсэн саналыг ялангуяа хуулийн зөвлөх, өмгөөлөгчид өгсөн байдаг. Гэхдээ энэ нь бизнес эрхлэгчдийн нийтлэг дүр зургийн хувьд хамгийн сүүлд эрэмбэлэгдсэн хэдий ч санал асуулгад оролцогчдын ихэнхэд энэ асуулт бодит байдал дээр төдийлөн хамааралгүй, томоохон бизнесийн байгууллагын хувьд илүүтэй хамааралтай юм.

Дээрхийг бүхэлд нь ажиглавал эрэмбийн хувьд хөндөгдсөн асуудлууд харьцангуй ойролцоо дараалалтай, ач холбогдлын хувьд ялгаагүй чухал байж болох байна. Мөн санал асуулгад оролцогчид үндсэндээ бүх бодомжийг дэмжсэн байна.


ТАВ. БИЗНЕСИЙН ОРЧИН НӨХЦӨЛ, АРИЛЖААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Судалгааны энэ хэсэгт Монгол Улс дахь бизнесийн өнөөгийн нөхцөл байдал, бизнес эрхлэгчдийн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээ оновчтой эсэх талаар ерөнхийд нь судалгаанд оролцогчдын байр суурийг танилцуулах болно.

5.1. Гэрээ, хэлцлийн талууд бие биедээ итгэх итгэлийн төвшин

Судалгаанд оролцогчид Монгол Улс дахь бизнесийн орчин нөхцлийн талаар, гэрээ, хэлцлийн талууд бие биедээ итгэх итгэлийн талаар үнэлэхдээ 3 хувь нь маш сайн, 10 хувь нь сайн, 55 хувь нь дунд, 17 хувь нь муу, 6 хувь нь маш муу гэсэн бол 9 хувь нь энэ талаар үнэлж мэдэхгүй гэжээ. Үүнийг бүхэлд нь дүгнэн үзвэл Монгол Улсад бизнес эрхлэхэд төдийлөн тохиромжтой бус буюу тааруу байгаа гэж дүгнэж байна.

График 19. Монгол Улс дахь бизнесийн нөхцөл байдал, гэрээ, хэлцлийн талууд бие биедээ итгэх итгэл



Түүнчлэн дээрх тоон үзүүлэлтийг үйл ажиллагааны салбараар нь авч үзвэл аль ч салбар тааруу үнэлгээ өгсөн байна.

График 20. Монгол Улс дахь бизнесийн нөхцөл байдал, гэрээ, хэлцлийн талууд бие биедээ итгэх итгэл (үйл ажиллагааны салбараар)





График 21. Монголын бизнесийн практикт тохиролцсондоо хүрэхгүй байх эрсдэл




Монголын бизнесийн практикт "ямартай ч гэрээ байгуулаад авъя, ажил эхэлсний дараа ямар нэг байдлаар тохирсноо өөрчлөх, эсхүл тохирсноосоо буцах, бүр болохгүй бол тохиролцоогоо цуцлах боломжтой" гэж үзэх хандлага нийтлэг байдаг эсэх талаар асуухад бизнес эрхлэгчдийн 21 хувь нь маш их, 26 хувь нь их, 34 хувь нь дунд зэрэг, 7 хувь нь бага, 5 хувь нь маш бага, 7 хувь нь огт байдаггүй гэж хариулжээ. Дээрхийг 1-6 оноонд шилжүүлж үзвэл **4.3 оноо буюу дундаас ихийн хооронд** буюу Монголын бизнес эрхлэгчид "тохиролцсондоо хүрэхгүй" байх эрсдэлтэй гэж нэг нь нөгөөгөө үнэлдэг байна.

5.2. Гэрээний тохиролцоог эрх зүй хамгаалж чадаж байгаа эсэх, шалтгаан

Гэрээний талууд бие биендээ итгэдэггүй, гэрээний үүргээ биелүүлдэггүй бизнесийн орчинд гэрээ, хэлцэлд итгэх итгэл доогуур байх нь ойлгомжтой бөгөөд харин гэрээ, хэлцэл хийсэн бол тэрхүү тохиролцоог нь хамгаалсан эрх зүйн орчинг бизнес эрхлэгчид хэрхэн дүгнэснийг анхаарах ёстой юм. График 20-д дурдсан "гэрээ, хэлцэл хийхдээ ярьсан тохирсондоо байх буюу хэлцэл заавал биелэгддэг байхад холбогдох эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх, сайжруулах шаардлагатай юу?" гэсэн асуултад энэхүү эрх зүйн орчинг өөрчлөх, сайжруулах шаардлагатай гэж 60 хувь нь үзсэн нь ихээхэн анхаарал татахуйц байна. Харин сайжруулах, өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн хувь бага байна.


График 22. Гэрээ, хэлцлээр хийсэн тохиролцоог хамгаалах эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх, сайжруулах шаардлага



Шигтгээ 7. “ЭПСЭО” ХХК-ийн хуулийн зөвлөхтэй хийсэн ярилцлагаас

... Гэрээ хийх гэж буй компанийн мэдээллийг шалгадаг байвал их зүгээр байна. Учир нь өртэй газруудтай гэрээ хийчихдэг бараа материал өгчихдөг дараа нь төлбөр тооцооны тал дээр маш их асуудал үүсдэг. Тэр болгон бизнес эрхлэгчээс шүүхийн шийдвэрийн лавлагаа нэхэх хүндрэлтэй байдаг. Тэр болгоныг цахимаар шалгадаг болчихвол баталгаат байдлыг тодорхой хэмжээгээр хангахад нөлөөлнө. Жишээ нь автомашины торгуулийн цахим хуудас шиг систем нэвтрүүлэх хэрэгтэй байна.

График 23. Бизнесийн болон гэрээ, хэлцлийн харилцаанд өөрийн байр суурь, эрсдэлээ хуулийн хүрээнд хангалттай хэмжээнд хамгаалж чадаж байгаа байдал



“Та өдөр тутмын бизнесийн болон гэрээ, хэлцлийн харилцаанд өөрийн байр суурь, эрсдэлээ хуулийн хүрээнд хангалттай хэмжээнд бүрэн хамгаалж чаддаг уу?” гэсэн асуултад буюу бизнесийн харилцаанд өөрийн байр суурь, эрсдлээ хуулийн хүрээнд хамгаалж чаддаг эсэх талаар судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 5 хувь нь бүрэн дүүрэн чаддаг, 36 хувь нь зарим талаар чаддаггүй, ерөнхийдөө тохиролцдог, 24 хувь нь зарим талаар чаддаггүй, төвөгтэй байдал үүсдэг, 17 хувь

нь чаддаггүй, огт хангалтгүй байна гэж үзжээ. Дээрх хангалтгүй байгаа шалтгааныг бизнес эрхлэгчид дараах байдлаар үзэж байна. /График 23/

График 24. Хуулиар бизнес эрхлэгч хоорондын гэрээний харилцааг хангалттай зохицуулсан эсэх, түүний шалтгаан



“Хуулиар (жишээлбэл, Иргэний хууль) бизнес эрхлэгч хоорондын гэрээний харилцааг хангалттай зохицуулсан эсэх, үгүй бол ямар шалтгаантай вэ?” (График 23) гэсэн асуултад бизнес эрхлэгчдийн олонх нь мэдэхгүй хэмээн хариулсан байна. Харин хангалтгүй гэж хариулсан санал асуулгад оролцогчид эрх зүйн зохицуулалт дутуу, ойлгомжгүй, иргэн хоорондын болон бизнес эрхлэгч хоорондын харилцаанд ижил зохицуулалт үйлчлэх нь оновчтой биш ялгамжтай өөр хуулиар зохицуулах нь зүйтэй, зарим зохицуулалт буруу, өөрчлөх шаардлагатай гэсэн саналыг дэмжсэн байна.

5.3. Бизнесийн харилцаанд тохирсон эрх зүйн орчинг бий болгох нь


Цаашид гэрээ, хэлцэлд холбогдох харилцааг сайжруулах, хуульчлах шаардлагатай талаар дараах саналыг дэмжсэн байна.

График 25. Бизнесийн харилцааг зохицуулсан эрх зүйн орчны хувьд дутмаг буюу сайжруулах шаардлагатай байгаа асуудал



“Бизнесийн харилцааг зохицуулсан эрх зүйн орчны хувьд дор дурдсан аль шинж одоогийн хуульд дутмаг буюу сайжруулах шаардлагатай байгаа гэж та үзэж байна вэ?” гэсэн асуултад энэ төрлийн харилцааг зохицуулсан хуульд хамгийн түрүүнд бизнес эрхлэгч нь бусдынхаа өмнө хариуцлагатай байх, итгэл даах байдлыг нэмэгдүүлсэн зохицуулалт тусгах явдал бөгөөд түүний дараа гэрээ, хэлцлийг түргэн шуурхай хийх бололцоог олгосон зохицуулалт, гэрээ хэлцлийн нөгөө талдаа итгэх итгэлийг хамгаалах зохицуулалт зэргийг тусгах гэжээ. Харин бусад гэсэн хариултыг нийт санал асуулгад оролцогчдын 6.4 хувь тэмдэглэл хийсэн байна.

График 26. Бизнес эрхлэгч хоорондын харилцааг зохицуулсан хууль (Commercial Code буюу Арилжааны хууль) гаргах хэрэгцээ, шаардлага




Цаашид бизнес эрхлэгч хоорондын харилцаатай холбоотой Иргэний хуулиас тусдаа шинэ хууль (Арилжааны хууль) бий болгох хэрэгцээ шаардлага бий эсэх (Бизнес эрхлэгч хоорондын харилцаатай холбогдох, энэ асуулгад дурдсан асуудлыг зохицуулсан хууль (Commercial Code буюу Арилжааны хууль) гаргах хэрэгцээ, шаардлага бий эсэх)-д судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 11 хувь нь байхгүй, 44 хувь нь байна гэж үзжээ. Харин 45 хувь буюу $\frac{1}{2}$ нь мэдэхгүй гэжээ. Түүнчлэн санал асуулгад бизнес эрхлэгчид тулгамдаж буй асуудал хэмээх 13 асуулт бүхий бодомжоос “хуульд нэрлэн заасан гэрээний зохицуулалтыг бизнес

эрхлэгчийн ашиг сонирхлыг хангах үүднээс системчилж, бие даасан тусгай хууль болгон батлах шаардлагатай байна” гэсэн хариулт 5 онооноос 3.76 оноо авсан нь судалгаанд оролцогчдын олонх нь бизнес эрхлэгчийн үйл ажиллагаанд зориулсан тусдаа хууль байх шаардлагатай гэж үзсэн болно.

Харин хуульч, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтний 62.5 хувь, бусад (График 26) оролцогчдын үндсэндээ талаас дээш хувь (худалдагч, борлуулалтын ажилтнаас бусад) нь бизнес эрхлэгч хоорондын харилцаатай холбогдох, энэ асуулгад дурдсан асуудлыг зохицуулсан хууль гаргах хэрэгцээ, шаардлага байна гэж дүгнэснээс үзвэл энэ талын эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна гэж дүгнэж болохоор байна. Харин хэлцэл хийх, бизнесийн үйл ажиллагаа явуулахад буюу эрх зүйн орчинг хамгийн их мэдэрдэг хэсэг болох хуульч, санхүү хариуцсан албан тушаалтан, гүйцэтгэх удирдлагын хувьд мэдэхгүй гэж хариулсан хувь харьцангуй бага, мөн Арилжааны хууль гаргах хэрэгцээ шаардлага байна хэмээн дэмжсэн хувьтай харьцуулахад мэдэгдэхүйц бага байгаа энэ асуудлыг хөндсөн, практикийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эрх зүйн хэм хэмжээ батлагдсан тохиолдолд бизнес эрхлэгчид эрх зүйн зохицуулалтыг амьдралд хэрэглэх магадлал өндөр байна. Гэхдээ ТУЗ-ийн дарга, гишүүд, салбар, нэгж хариуцсан албан тушаалтан, худалдаа, борлуулалт хариуцсан ажилтнуудын хувьд үндсэндээ дэмжсэн, эсхүл мэдэхгүй гэж хариулсан хувь ойролцоо байгаа нь анхаарал татаж байгаа ба энэ нь хуулийн агуулгаас хамааран байр сууриа тодорхойлоогүй байгаатай холбоотой болов уу.


График 27. Бизнес эрхлэгч хоорондын харилцааг зохицуулсан хууль (Commercial Code буюу Арилжааны хууль) гаргах хэрэгцээ, шаардлага (ажил, албан тушаалаар)



5.4. Бизнесийн маргаан шийдвэрлэх процессын эрх зүйн асуудал

Бизнес эрхлэгчдийн харилцааг тухайлан зориулсан тусгайлсан хэм хэмжээ болох материаллаг хэмжээний хэрэгцээ, шаардлагыг голлон энэ судалгааны хүрээнд тандсан хэдий ч бизнес эрхлэгчдэд хамааралтай процессын эрх зүйн зохицуулалтыг тодорхой хэмжээнд авч үзсэн болно.

График 28. Бизнес эрхлэгчдийн маргааныг шийдвэрлэх одоогийн тогтолцоо, шүүхийн процесс шаардлага хангаж байгаа эсэх



Бизнес эрхлэгчдийн аливаа маргааныг шийдвэрлэх одоогийн тогтолцоо, шүүхийн процессын талаар асуухад (Бизнес эрхлэгчдийн хооронд гарах аливаа маргааныг шийдвэрлэх одоогийн тогтолцоо, шүүхийн процессыг хангалттай сайн гэж Та үзэж байна уу?) одоогийн тогтолцоо, процессыг 5 хувь нь хангалттай сайн, 31 хувь нь хангалтгүй, мэргэшсэн шүүх, арбитр хэрэгтэй, 23 хувь (График 27) нь бизнесийн онцлогийг тусгасан шүүх, арбитрын ажиллагааг зохицуулсан хэм хэмжээ хэрэгтэй гэж хариулсан. Энэ нь бизнесийн үйл ажиллагаанд хамааралтай материаллаг эрх зүйн нарийвчилсан зохицуулалт шаардлагатай байхын зэрэгцээ процессын хэм хэмжээнд давхар анхаарал хандуулах шаардлага байна гэж бизнес эрхлэгчдийн олонхи (зөвхөн 5 хувь нь хангалттай сайн) нь үзэж байна. Иймээс институцийн хувьд дагнасан шүүх, мэргэшсэн арбитрын бүтэц байхыг дэмжсэн, шүүх, арбитрын ажиллагаа явуулах процессын хэм хэмжээ бизнесийн онцлогийг харгалзах ёстойг харуулж байна.

5.5. Судалгааны хүрээнд хөндөгдсөн бусад асуудал

Ярилцлагын судалгааны хүрээнд бизнес эрхлэгчид, тэдний гол мэдээлэгч (*key informant*) нараас ганцаарчилсан ярилцлагын аргаар цуглуулсан мэдээлэл болон санал асуулгын судалгааны нээлттэй асуултын хүрээнд өгсөн хариултыг нэгтгэн ав үзвэл:

- ✓ Бизнес эрхлэгч хоорондын болон иргэд хоорондын харилцаанаас үүсэх талуудын эрх, үүрэг, хариуцлага ямагт ялгаатай байдаг тул үүнийг харгалзан үзсэн эрх зүйн зохицуулалт шаардлагатай байгаа болохыг судалгаанд оролцогчид онцолж байсны зэрэгцээ эдгээр харилцааг нэг хууль (Иргэний хууль)-иар зохицуулж байгаа нь зохимжгүй гэж үзсэн болно. Өөрөөр хэлбэл, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны онцлогт нийцсэн хууль тогтоомж шаардлагатай байна.

Шигтгээ 8. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг компанийн захиралтай хийсэн ярилцлагаас

... Бизнес эрхлэгч хоорондын болон иргэд хоорондын харилцааг ялгаатай гэж үзэж байна. Учир нь иргэд хоорондын үүргийн харилцаа нь тодорхой нэг хүрээнд багтсан, харьцангуй энгийн харилцаа бол бизнес эрхлэгч хоорондын үүргийн харилцаа нь илүү өргөн хүрээнд, мэргэжлийн түвшинд эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлсон харилцаа байдаг. Иймд эдгээр харилцааг нэг адил эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах нь зарим талаараа яавч оновчтой биш юм. Ялангуяа тавигдах шаардлага, шалгуур, хариуцлагын хувьд нэн ялгамжтай байх шаардлагатай гэж үзэж байна.

- ✓ Бизнес эрхлэгчдийн хооронд байгуулж байгаа зарим төрлийн гэрээ, хэлцэлд нотариатаар гэрчлүүлэх, улсын бүртгэлд бүртгүүлэх зэрэг хэлбэрийн шаардлага хууль тогтоомжоор тогтсон байдаг. Энэ нь бизнесийн үйл ажиллагаанд цаг хугацааг удаашруулж, алдагдалд хүргэх үр дагавартайн зэрэгцээ бизнес эрхлэгчдийн хоорондын харилцаанд үл ойлголцол үүсгэдэг. Мөн бизнес эрхлэгчдийн хоорондын харилцаанд тусгайлсан гэрээ, хэлцлийн төрлүүдийг нэмэх, заавал бичгээр хийх, нотариатаар гэрчлүүлэх, улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулахгүйгээр түргэн шуурхай, уян хатан байдлыг харгалзан үзэж цахим хэлбэрээр, нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн гүйцэтгэх боломжуудыг эрэлхийлэх нь зүйтэй гэж хариулсан байна.

Шигтгээ 9. Хүлэмжийн аж ахуй, хүнсний ногоо тариалалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “М” ХХК-ийн захиралтай хийсэн ярилцлагаас

... Хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуйн үйл ажиллагаагаар бизнес эрхлэгчдийн хувьд зарим нэг гэрээ, хэлцлийг баталгаажуулах гээд нотариат, улсын бүртгэл, ... төрийн байгууллагуудаар явах үнэхээр хэцүү байдаг. Учир нь нэг л өдөр, хэдэн цаг хоромд хүнсний ногоо, нарийн ногоо болон жимс жимсгэнийг арчлаагүйгээс бид ихээхэн алдагдалд ордог.

- ✓ Хуулийн этгээд байгуулахгүйгээр бизнес эрхлэгчид нь бизнес эрхлэгчдийг төлөөлөх эрхгүй этгээд гэрээ хэлцэл байгуулсны үр дагавартай холбоотой асуултанд тодорхой хариултыг өгөөгүй. Харин хуулийн этгээд байгуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа бизнес эрхлэгчдийн хувьд төлөөлөх эрхтэй этгээд буюу гүйцэтгэх удирдлагын талаарх мэдээлэл гэрээ хэлцэл байгуулахад тодорхой байх нь зүйтэй гэж үзсэн. Мөн зарим тохиолдолд төлөөлөх эрхгүй этгээдтэй гэрээ, хэлцэл байгуулсны улмаас хохирсон, тухайн бизнесийн үйл ажиллагаа цаашид үргэлжлэх боломжгүй болсон, хөрөнгө оруулалт зогссон, буцаан татагдсан гэж хариулсан. Гэтэл зарим тохиолдолд гүйцэтгэх удирдлагад багагүй хэмжээний эрх мэдэл олгосны улмаас тухайн бизнесийг үүсгэн байгуулагч хохирсон төдийгүй гуравдагч этгээдийн өмнө өөрөө хариуцлага хүлээсэн талаар ч дурьджээ.
- ✓ Монголын төдийгүй гадаадын бизнес эрхлэгчдийн хувьд салбар, төлөөлөгчийн газраар дамжуулан бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хэдий ч зарим тохиолдолд салбар, төлөөлөгчийн газраар дамжуулан бизнес эрхлэх боломжгүй талаар хариулжээ. Тухайлбал, уул уурхайн салбарт тусгай зөвшөөрөл бүхий компанийн салбар, төлөөлөгчийн газраар дамжуулан ашигт малтмал олборлох талаар хууль тогтоомжийн тодорхой зохицуулалт байхгүй байна. Үүний улмаас хөрөнгө оруулагчидтай харилцан тохиролцох боломжгүй, тухайн бизнесээс олж буй ашиг, орлогоо тодорхойлох, цаашид зээл авах, хөрөнгө оруулалт татах зэргээр бизнесээ өргөжүүлэхэд үргэлж бэрхшээл тулгардаг болохыг илэрхийлсэн байна.

Шигтгээ 10. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “ДЧ” ХХК-ийн гүйцэтгэх захиралтай хийсэн ярилцлагаас

... Уул уурхайн компанийн хувьд тусгай зөвшөөрөл бүхий уурхайнууд орон нутаг буюу аймгуудад үйл ажиллагаагаа явуулахад заавал салбар, төлөөлөгчийн газар байгуулах шаардлага үүсдэг. Салбар, төлөөлөгчийн газар байгуулсан ч тэдгээр

нь үйл ажиллагаагаа бие даан явуулах эрх зүйн орчин дутмаг, заавал толгой буюу Улаанбаатар хотод байгаа компаниар бичиг баримтаа албажуулах шаардлага үүсдэг.

- ✓ Ярилцлагын судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдээс бизнесийн нууцыг мэдэх ажилтан, хамтрагч, удирдах албан тушаалтан өрсөлдөгч аж ахуй нэгжид ажиллах, адил төрлийн бизнес эрхлэх зэргийг хязгаарлах, бизнесийн нууцыг хамгаалсан, тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулсан хууль тогтоомж нэн шаардлагатай байгааг чухалчилсан байна. Ийнхүү бизнес эрхлэгчдийн бизнесийн нууц алдагдсан, өрсөлдөгч бизнес эрхлэгчтэй нь хамтран ажилласны улмаас хохирол учирсан тохиолдолд маргаан үүсгэх боломжгүй байдаг талаар онцлоод энэхүү харилцааг хуульчлах нь зүйтэй гэж хариулжээ. Харин зарим бизнес эрхлэгчид хариулахдаа, заавал хуульчлах шаардлагагүй, бизнесийн ёс зүйтэй байхад л бүрэн шийдвэрлэгдэх асуудал гэж хариулсан байна.

Шигтгээ 11. Барилгын үйл ажиллагаа эрхэлдэг компанийн захиралтай хийсэн ярилцлагаас

... Эрх шилжүүлэх гэрээ, контракт гэрээ гэх мэт гэрээнүүд байдаг. Гэхдээ хязгаарласан зохицуулалт шаардлагатай. Энэ бол нөгөө талаас бизнес гэдэг бол өрсөлдөөн тодорхой нууц дээр явдаг өрсөлдөөн тухайн бизнес эрхлэгчийн амжилттай ажиллах үндэс нь бизнесийн нууц, түүнийг мэдэж аваад өөр байгууллагад ажиллана гэдэг бол шударга ёсны зарчимтай зөрчилддөг тэгэхээр энэхүү хязгаарлалтыг оруулах шаардлагатай гагцхүү хэрэгжүүлэх механизм болон хяналт яаж хэрэгжих вэ гэдэг хэцүү. Нэг компаниас нөгөө компанид орж байна гэдгийг хянах боломжтой юу гэдэг бол одоогоор хэцүү бөгөөд чухал асуудал. Шаардлагатай юу гэвэл шаардлагатай, харин хяналт тавих тогтолцоо бол одоогийн байдлаар хэцүү л юм.

- ✓ Бизнес эрхлэгчийн ашгийн төлөө зорилгыг хамгаалах, гэрээ, хэлцлийн найдвартай баталгаат байдлыг хангах, зохих ёсоор биелүүлэхэд бизнес эрхлэгчдийн хоорондын харилцаа, улсын бүртгэл, төрийн байгууллагын шийдвэр, олон нийтэд тараагдсан сөрөг мэдээлэл зэрэг нь шууд болон шууд бус байдлаар нөлөөлж байна. Түүнчлэн бизнесийн үйл ажиллагааны ашиг, орлогыг нэмэгдүүлэхэд бизнес эрхлэгчдийн болон ажилтнуудын мэргэжлийн ур чадвар болон ёс зүйн доголдол, мэргэшсэн байдал дутмаг зэрэг нь нөлөөлж байгааг тодорхойлсон байна.

- ✓ Бизнес эрхлэгчид төлөөлөх эрхгүй этгээдтэй түрээсийн гэрээ байгуулсан, түрээсийн гэрээг улсын бүртгэлд бүртгүүлээгүйн улмаас уг гэрээ хүчин төгөлдөр бус гэж тооцогдох тохиолдол цөөнгүй байдаг, үүнээс болж хохирсон тухайгаа дурджээ. Мөн түрээсийн төлбөрийг ямар ч үндэслэлгүйгээр нэмсний улмаас үйл ажиллагаа доголдох тохиолдол байгаа талаар өгүүлсэн байх бөгөөд үүнээс болж хөрөнгө оруулалт, зээлийн эргэн төлөлт удааширч бусдын өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болдог гэжээ.

Шигтгээ 12. Төсөл хэрэгжүүлдэг компанийн захиралтай хийсэн ярилцлагаас

... Гэрээний чөлөөт байдал байдаг гэх хэдий боловч бизнес эрхлэгч, иргэн хоёрын хооронд гэрээ байгуулахад гэрээний нөхцөлийг тэр бүр нарийвчлан тодорхойлж хэрэгжүүлэх боломжийг Иргэний хуулиар хязгаарласан байдаг. Үүнээс болж гэрээнд оролцогч талуудын эрх зөрчигдөх үндэс болдог, Иргэний хуулийн зарим зүйл заалт зохицуулалт нь өнөөгийн нийгэм, зах зээлийн харилцаанаас хоцорсон, үүссэн нийгмийн харилцааг тухайлан зохицуулж чадахгүй байна.

Судалгаанд оролцогчид нь бизнес эрхлэгч, иргэд хоорондын бизнесийн харилцаанд учирч буй хүндрэл, бэрхшээл, тулгамдаж буй асуудлуудын талаар санал бодлоо нээлттэй солилцож, харилцан ярилцсан. Энэхүү асуултын хүрээнд гэрээ, хэлцлийн хүчин төгөлдөр байдал, хэрэгжилтийг сайжруулах, бизнес эрхлэгчдийн болон иргэд хооронд үүссэн шүүхийн маргаан, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа удаашралтай байдаг. Төрийн байгууллагын шийдвэр, улсын бүртгэл, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа гэх мэт эрх бүхий байгууллагаас бизнес эрхлэхэд шууд нөлөөлөх дарамт их гэжээ.

Харин бизнес эрхлэгчдийн хоорондын харилцааг зохицуулсан шинэ хууль боловсруулбал одоо байгаа зохицуулалтыг дараах байдлаар сайжруулах шаардлагатай гэж судалгаанд оролцогчид бичгээр санал гаргасан байна. Үүнийг ямарваа засваргүйгээр, эрэмбэлэхгүйгээр дор дурдвал:

- *Тодорхой нөхцөл байдалд зээлийн хүүг бууруулах ч юм уу эсвэл түрээсийг хойшлуулж болдог байх. (Covid-19 буюу цар тахал гэх мэт хорио цээрийн дэглэмийн одоогийн нөхцөлд);*
- *Гэрээ хэлцэл хийхэд үүсэх маргааныг шийдэх хууль хэрэгтэй;*
- *Хувиараа бизнес эрхлэгч нарын түрээсийг дур зоргоороо нэмдэг, шахаж дарамталдаг (жишиг) эсхүл бусдын адил м.кв үнэ адил байлгах;*

- Даруй боловсруулах шаардлагатай гэж бодож байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, жижиг дунд үйлдвэр эрхлэгчид олширч байгаатай холбогдуулан зайлшгүй нөхцөл шаардлага, эрх зүйн орчин шаардагдаж байна;
- Арилжааны хуульд бизнес эрхлэгчдийг эрэмбэлж, тухайн эрэмбэд хамаарах зохицуулалт хэрэгтэй. Өндөр ашиг олдог бизнес эрхлэгчид нь бага ашиг олдог бизнес эрхлэгчдээ хөлдөө чирэх явдал их бий;
- Бизнес эрхлэгчдэд тулгарч байгаа түрээслэгчийн түрээсийн өндөр дарамттай хязгаар тогтоох (м.кв) түрээсийн төлбөрийг улсаас хатуу тогтоож өгөх;
- Түрээслэгчид өөрийн давуу эрхээ ашиглан түрээслэгчдийн эрх ашгийг хохироох, гэрээгээ өөрсдөдөө ашигтайгаар байгуулахыг хязгаарлах зохицуулалт, түүнийг хянах хууль хяналтын байгууллага шаардлагатай;
- Гэрээний хугацаанд яг гэрээний нөхцөлөөр ажиллах хэрэгтэй байна. Ямар ч УИХ-ын гишүүн, өндөр албан тушаалтан болон жирийн иргэдэд хууль тэгш үйлчилдэг баймаар байна. Түрээсээ гэрээний хугацаа дуусахаас өмнө огцом нэмсэн. Түрээслэгчид хохироод үлдсэн. Ямар ч хууль батлагдсан бай, тэр хууль иргэдийн талд үйлчилдэг биш дээ;
- Бизнес эрхлэгчдийн аливаа асуудлыг зөв, шударга шийддэг хуулийн зөв орчинг бүрдүүлэх хэрэгтэй байна;
- Түрээслэгчдийн эрх ашгийг харгалзан үзэж түрээсийн төлбөрийг уян хатан байлгаж байх шаардлагатай;
- Жижиглэн болон бөөний худалдааны бизнес эрхэлдэг хүмүүсийг хамгаалах эрх зүйн орчин, хууль, дүрэм маш хангалтгүй;
- Бизнес эрхлэгчдийн хоорондын харилцааг зохицуулсан шинэ хууль боловсруулах хэрэгтэй. Цаашдаа ч ийм харилцаа нэмэгдэх тул тэдний хоорондын харилцааг зохицуулсан эрх зүйн орчингүй улмаас олон бизнес хумигдаж, өөрөөр хэлбэл дампуурч байна;
- Бизнес эрхлэгчдийг дэмжихэд зарим тохиолдолд гэрээ зөрчигдсөн бол харилцан тохиролцож буулт хийх хэрэгтэй;
- Ижил бизнес эрхэлдэг бол бие биендээ төвөг болохуйц асуудлыг нь шийдвэрлэх талаар хуульчилж өгөх;
- Бизнес эрхэлдэг аж ахуйн нэгж, хувь хүн хоёрыг ялгах нь зөв, тэдний эрх ашгийг нэгтгэн хуульчилж болохгүй;
- Ард иргэд, бизнес эрхлэгч гуравдагч этгээд хүчин зүйлүүдээс хамаарсан хүмүүсийн саналыг сонсож зохицуулалтыг бүгдийн эрх ашигт нийцсэн гаргавал зүгээр байна;
- Гэрээний алданги мөн хариуцлага өндөр болгох;
- Одоо хэрэгжиж буй хуулийн зохицуулалтыг сайжруулах хэрэгтэй;

- Арилжааны хуульд бизнес эрхлэгчдийг эрэмбэлж түүнд таарсан зохицуулалт хэрэгтэй. Өндөр ашиг олдог бизнес эрхлэгчид нь бага ашиг олдог бизнес эрхлэгчдийг шахах явдал их бий;
- Татварын хөнгөлөлт (шинээр эхэлж буй эсвэл улирлын чанартай бизнес эрхэлж буй хүмүүст уян хатан хандах);
- Одоо байгаа зохицуулалтыг сайжруулах шаардлагатай, бизнес эрхлэгчдийн санал асуулгыг нягталж, эрх зүйн дүгнэлт хийж шинэчлэх;
- Бараа бүтээгдэхүүн худалдан авсан иргэд, бараа бүтээгдэхүүн буруу ашиглалтаас болж гарах эрсдэлийг яаж зохицуулах, хэн хариуцлага хүлээх талаар мэдээлэл бас чухал;
- Бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалж, зайлшгүй гарахад хүргэдэг мөнгөн болон бусад зардлыг бууруулах хуулийн зохицуулалт;
- Бизнес эрхлэгчийн ашгийн төлөөх зарчмыг хангах талаар зохицуулалт тодорхойгүй учраас бизнесийн үйл ажиллагаанд хүндрэл учирч байдаг;
- Түрээслүүлэгч тал хэт их эрх мэдэлтэй, түрээсийн төлбөрөө авахын тулд бусдын бараа бүтээгдэхүүнийг хураах, лацдах битүүмжлэх зэрэг арга хэмжээ авдаг. Түрээслэгчдийн эрх ашгийг хамгаалах. Улс орон даяар түрээсийн төлбөр хэт өндөр байгаа нь олон бизнес эрхлэгчдийг дампууруулсан;
- Шударга өрсөлдөөн хэрэгтэй, хэн дуртай нь нэгнийхээ барааг дуурайж зардаггүй тогтолцоог бий болгох;
- Шүүхийн шийдвэр гарсны дараах буюу шийдвэр гүйцэтгэл удаан байгаа, гэрээний үнийн дүнгийн алдангийг одоо мөрдөгдөж байгаа алдангийн хувиас тодорхой шаардлага цензурын дагуу өсгөдөг байх. Жишээ нь 2 дахин 3 дахин нугалж төлнө г.м;
- Зөрчил, дутагдал, хүн хуурсан бизнес эрхлэгчдийг дахин бизнес эрхлэх үйл ажиллагааг хязгаарлах, энэхүү хязгаарлалтыг бусдад төлөх төлбөрийг бүрэн төлтөл хэвээр байлгамаар байна;
- Худалдааны хуультай болох. Шүүхийн процессийг хялбаршуулах, хэрэг хянан шийдвэрлэх хугацааг хэргийн нөхцөл байдал, нэхэмжлэлийн үнийн дүнгээс хамааруулан богиносгох хэрэгтэй;
- Хувь хүн иргэний тоон гарын үсэг юмуу дижитал хэлбэрийг эрх зүйн хүрээнд баталгаажуулах;
- Бизнес эрхлэгчдийн хоорондын гэрээ хэлэлцээрийг илүү уян хатан болгох, эрх зүйн орчинг сайжруулах;
- Ижил бизнес ялангуяа зургийн студийн үйл ажиллагааг явуулдаг байгууллагуудын байрлах хоорондын зай (500м-т) г.м. байх;
- Түрээсийн байрыг дулаан байлгах, эрүүл ахуйн талаас анхаарах;
- Хөөн хэлэлцэх хугацаа. Төлбөрөө барьцааны хөрөнгөөр хангуулах үйл ажиллагаа. Зээлдэгч, зээлдүүлэгч хооронд байсан гэрээнд барьцааны

хөрөнгийн үнэлгээг тогтоох бус тогтоосон үнэлгээг төлбөрийг барагдуулахад хэрэглэх;

- Гэрээ байгуулагдсанаар 2 талд хариуцлага заавал бий болгох, эрх үүргийг (тэй) шударга тооцож байх, хариуцлага хүлээх чадварыг бий болгох;*
- Ижил төрлийн бизнесийн хоорондын зайг зохицуулах /стандартын дагуу/;*
- НӨАТ-ын буцаан олголтыг хувь нэмэгдүүлэх, хонжвор, сугалааг байхгүй болгох, бизнесийн дарамт, нөлөөлөл, намчирхах байдлыг харж үзэх;*
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сайжруулах, ойлгомжтой болгох шаардлагатай;*
- Татвар болон түрээсийн төлбөр зэрэг дээр уян хатан байх нөхцлийг бүрдүүлбэл зүгээр байх;*
- Цахим гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх тал руу зохицуулалт хийх;*
- Монгол Улсын бизнесийн үйл ажиллагааны тухай хуулийг дэлгэрэнгүй болгож бизнес эрхлэгч байгууллага, иргэд хоорондын харилцааг тусгай хуулиар зохицуулдаг байх. Бизнес эрхлэгчдийн ашгийн тухай зохицуулалт болон, хамтрагчдын хоорондын харилцаа, тэдний хариуцлагыг тодорхой болгох зэрэг орно.*

Дээр дурдагдсан нээлттэй асуултад хариулт өгсөн, ярилцлагын агуулгыг ерөнхийд нь дүгнэн үзвэл бизнес эрхлэгч тус бүр өөрт тулгамдаж буй асуудлуудыг нэрлэн заасан боловч үүнээс нийтлэг ажиглагдаж байгаа зүйл нь бизнес эрхлэгчийн үйл ажиллагаанд нийцсэн иргэд хоорондын хэлцлээс ялгамжтай эрх зүйн зохицуулалт бий болгох, талууд гэрээ байгуулсан бол заавал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлдэг байх буюу итгэлцлийг нэмэгдүүлэх, түрээсийн гэрээний асуудал, гэрээний үүргээ зөрчсөн бол хүлээх хариуцлагыг тодорхой болгох талаар дурдсан байна. Мөн Арилжааны хуулийн хүрээнд хөндөгдөхгүй татвар, хураамж зэрэг асуудлыг дурдсан байх тул эрх зүйн системчлэлдээ дээр дурдсан хариултыг ялгамжтай авч үзэх нь зүйтэй юм.

ЗУРГАА. СУДАЛГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Энэ хэсэгт судалгааны 4, 5 дугаар хэсгүүдэд хийгдсэн санал асуулгын болон ярилцлагын судалгаанд хөндөгдсөн асуудлуудыг задлан шинжилсэн болно. Ингэхдээ санал асуулгын судалгааны бүтцийн хувьд бизнес эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах, хэлцлийн баталгаат байдал болон түргэн шуурхай байдлыг хангах гэсэн асуудлыг хүрээнд тодорхой асуудлуудыг тус тусад нь тайлбарласан. Харин энэхүү задлан шинжилгээний хэсэгт одоогийн эрх зүйн орчинд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд тулгарч байгаа асуудлууд, түүнчлэн эрх зүйн хувьд зохицуулагдаагүй, цаашид зохицуулах шаардлагатай харилцаа гэсэн хоёр төвшинд задлан шинжилгээ хийсэн болно.

6.1. Одоогийн эрх зүйн орчинд тулгамдаж буй асуудал

Төлөөллийн асуудал

Юуны түрүүнд өнөөгийн эрх зүйн орчинд бизнес эрхлэгчийг төлөөлөн хэлцэл хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийг төлөөлөх бүрэн эрхийн асуудал чухалаар хөндөгдөж байна. Өөрөөр хэлбэл, бизнес эрхлэгч нь зөвхөн дангаараа бүх бизнесийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах боломжгүй тул зайлшгүй тодорхой субъектүүдэд бүрэн эрх олгох замаар бизнесийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зорилгоор төлөөллийн харилцаа үүсгэдэг. Энэ нь иргэдийн хувьд ч байдаг тодорхой үйлдлийг бусад этгээдээр төлөөлүүлэн хийх ойлголттой адил боловч бизнесийн харилцааны онцлог шинжээс хамаарч ялгамжтай зохицуулалт шаардлагатай болдог. Гэвч манай улсын одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд ашгийн төлөө хуулийн этгээд болох компанийг төлөөлөх бүрэн эрхийг зөвхөн гүйцэтгэх захиралд олгохоор зохицуулсан нь хэлцэл хийхэд цаг хугацаа шаардагдах, хэлцлийн хүчин төгөлдөр байдлын талаар маргаан гарах эрсдлийг үүсгэдэг. Түүнчлэн дан ганц хуулийн этгээдээр хязгаарлагдахгүй хувиараа бизнес эрхлэгчийг төлөөлөх, түүний бүрэн эрхийг Иргэний хуулийн төлөөлөл, итгэмжлэлийн зохицуулалт үйлчилж байгаа нь оновчтой эсэх талаар судлах нь судалгааны нэг үндсэн хэсэг болсон.

Үүнтэй холбоотойгоор судалгаанд оролцогчид бизнес эрхлэгчийг төлөөлөх асуудалд хэрхэн үнэлэлт дүгнэлт өгсөн талаар авч үзвэл (График 9) нийт судалгаанд оролцогчдын 57 хувь нь итгэмжлэлгүйгээр төлөөлөх зохицуулалт хангалтгүй гэж хариулсан болно. Харин илүү мэргэшсэн оролцогчид болох хуульч, санхүү хариуцсан албан тушаалтны 62-оос дээш хувь нь одоогийн эрх зүйн зохицуулалт хангалтгүй гэж дүгнэсэн. Үүнээс үзвэл бизнес эрхлэгчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх одоогийн эрх зүйн зохицуулалтыг эргэн харж, Иргэний хууль дахь төлөөллийн харилцаанаас бизнес эрхлэгчийн төлөөллийн харилцааг ялгамжтайгаар авч үзэх шаардлагатай болохыг харуулж байна.

Хөөн хэлэлцэх хугацаа

Одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд хөндөгдөж байгаа дараагийн асуудал нь бизнесийн гэрээ хэлцэлтэй холбоотой хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт юм. Судалгаанд оролцогчид гэрээний хөөн хэлэлцэх хугацаа урт, эсхүл богино байгаа талаар тодорхой саналгүй байх бөгөөд (График 12) энэ талаар нарийн мэдэхгүй байна. Гэхдээ хандлагын хувьд хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой одоогийн эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх санал зонхилж байгаа ба энэ байр суурь мэргэжлийн хүмүүс болох хуульчдын дунд ч ажиглагдаж байна. Тодруулбал, одоогийн байгаа эрх зүйн зохицуулалтыг дэмжсэн 14 хувь байгаа бол,

өөрчлөхийг дэмжсэн хувь (хугацааг богиносгох-12 хувь, уртасгах-26 хувь, тоолох аргыг өөрчлөх-11 хувь, буюу нийт 49 хувь) байгааг анхаарах нь зүйтэй юм.

Судалгаанд оролцогчдын 37 хувь нь бизнес эрхлэгчдийн хооронд байгуулагдаж буй гэрээ, хэлцлийн хөөн хэлэлцэх хугацаа (3 жил) урт, эсхүл богино байгаа талаар тодорхой санал гараагүй буюу “мэдэхгүй” хэмээн хариулсан нь энэ талаар ямарваа нэг практик туршлага байхгүйтэй холбоотой байна. Нийтлэг тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа нь өдөр тутам амьдралд хэрэглэгдэхгүй, зөвхөн маргаан гарсан тохиолдолд шаардах эрхээ хэрэгжүүлэх боломжтой эсэхэд шууд нөлөөлдөг болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Гэрээ, хэлцэлд тавигдах шаардлага

Дараагийн асуудлын хувьд гэрээ, хэлцлийн хэлбэрийн шаардлагын тухай асуудал юм. Өөрөөр хэлбэл бизнесийн харилцааны нэг онцлог нь аль болох хурдан, шуурхай, зардал багатайгаар хэлцэл хийж бизнесийн ашгаа нэмэгдүүлэх боломжийг бий болгож байдаг. Нөгөө талаар нэгэнт бизнес эрхлэгч, хамтрагчдын дунд тогтсон бизнесийн зөв практикийг хүлээн зөвшөөрч, хэрэг маргааныг шийдвэрлэхэд удирдлага болгох нь талуудын хүсэл зоригт нийцсэн байхаас гадна байнгын хувьсан өөрчлөгддөг бизнесийн талбарт тохиромжтой байдаг тул Арилжааны эрх зүйд эрх зүйн эх сурвалж болдог. Харин манай улсын хувьд гэрээ, хэлцлийн хэлбэрийн хувьд хуульд заавал бичгээр байгуулах, тодорхой хөндлөнгийн субъектээр баталгаажуулах зэрэг шаардлага тавьснаас бусад тохиолдолд өөр гэрээ, хэлцэл байгуулахыг зөвшөөрөх боловч, энэ нь иргэд хоорондын болон бизнес эрхлэгч хоорондын харилцааны онцлогоос үл харгалзан ялгамжгүй зохицуулагдсан.

Тиймээс эл асуудлын хүрээнд бизнесийн гэрээ, хэлцэлд тавигдах шаардлагыг багасгах, урт хугацаанд хамтран ажилласан бизнес эрхлэгчдийн дунд бий болсон практикыг хүлээн зөвшөөрөх талаарх байр суурийг судалсан. Судалгаанд оролцогчдын 41 хувь нь бүх тохиолдолд гэрээ, хэлцлийг бичгээр хийх ёстой гэж үзсэн. Энэ үр дүн нь Монголын нөхцөлд хэлцлийн талууд бие биедээ итгэх итгэл буурсантай тодорхой хэмжээгээр хамааралтай юм (График 18 үзнэ үү). Хэлцлээ аман хэлбэрээр байгуулаад жич бичгийн хэлбэрт оруулна гэдгийг дэмжсэн 28 хувь ч мөн адил талуудын хоорондыг итгэлцэл буурсан нөхцөл байдалтай холбоотой бөгөөд хожим бичгийн хэлбэрт оруулахыг хүсч байгаа нь тохиролцоо, хүсэл зоригийн агуулгын талаар маргаан үүсэхээс сэргийлэх зэрэг нотлох баримтын ач холбогдлыг чухалчилж байгаад оршино.

Нөгөө талаар бизнес эрхлэгчдийн хувьд гэрээ, хэлцэл байгуулах зардал, цаг хугацаанаас илүүтэйгээр маргаан гарах тохиолдолд баталгаат байдлыг чухалчилж үздэг гэж дүгнэж болно. Түүнчлэн маргааныг шийдвэрлэж буй шүүхийн хувьд ч

бичмэл нотлох баримтад үндэслэж шийдвэр гаргах, талуудаас тайлбар, үндэслэлээ нотлохыг шаардагтай холбоотой гэдгийг дурдах нь зүйтэй. Арилжааны заншил, тогтсон практикийн талаар шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд талуудын хооронд тогтсон практик байгаа талаар нэхэмжлэлийн үндэслэлээ болгосон байхад шүүхээс түүнд дүгнэлт өгөхгүйгээр шийдвэрлэсэн маргаан цөөнгүй байгаа нь үүний нэг нотолгоо болно. Эдгээрээс дүгнэн үзэхэд бизнес эрхлэгчдийн хувьд ч одоогийн хууль тогтоомжийн гэрээ, хэлцэлд тавигдах хэлбэрийн шаардлагын талаарх зохицуулалтыг зайлшгүй өөрчлөх шаардлагатай гэсэн байр суурийг хатуу баримтлаагүй байна.

Хуульд заасан хүү

Хэдийгээр одоогийн Иргэний хуульд “үүрэг гүйцэтгэгч мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол тохирсон хүү төлөх үүрэгтэй” гэж зохицуулсан байдаг. Энэ нь хэрвээ үүрэг гүйцэтгэгч хугацаандаа үүргээ гүйцэтгэсэн бол үүргийн гүйцэтгэл болох мөнгийг дахин эдийн засгийн эргэлтэнд оруулах замаар үүрэг гүйцэтгүүлэгч ашиг олох боломжийг хадгалах буюу мөнгө унддаггүй гэх зарчмыг хэрэгжүүлэх бодит хамгаалалт болдог. Ялангуяа, бизнес эрхлэгчдийн хувьд түргэн хугацаанд олон давтамжтайгаар мөнгийг эргэлтэнд оруулах нь төдий чинээ ашиг олох боломжийг нэмэгдүүлдэг тул нэгэнт тохирсон бол тухайн хугацаандаа үүргээ гүйцэтгэдэг байх баталгааг арилжааны эрх зүйгээр бүрдүүлж өгдөг.

Гэвч дээрх зохицуулалт нь иргэд хоорондын хэлцэл үү? эсхүл бизнес эрхлэгч хоорондын хэлцэл үү? гэдгээс үл хамааран нийтлэг зохицуулалттай байх бөгөөд шүүхийн практикаас үзэхэд хэрэгжилтийн хувьд ихээхэн ялгаатай байр суурь ажиглагддаг. Тиймээс одоогийн энэхүү олон хувилбартай зохицуулалтыг өөрчлөх байдлаар бизнес эрхлэгч гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй тохиолдолд хуульд заасан хэмжээний хүү, эсхүл хуульд заасан аргагчлалын дагуу тооцсон хүү шаардах эрхтэй байх шаардлага бий эсэхийг асуухад судалгаанд оролцогчдын 70-аас дээш хувь нь хүлээн зөвшөөрсөн хариулт өгсөн.

Үүнээс дүгнэхэд одоогийн хууль тогтоомжид заагдсан “тохирсон хүү” гэх ойлголтыг “хуульд заасан хүү” болгон өөрчлөх шаардлагатай болохыг харуулж байна.

Дээрх асуудлуудаас гадна бизнес эрхлэгчдийн хоорондын гэрээ, хэлцэлд холбогдох эрх зүйн зохицуулалтыг сайжруулах ямар чиглэл байгааг олон сонголттой асуултаар тандсан болно. Үүний үр дүнг нэгтгэвэл 30 орчим хувь нь үл маргах журмаар төлбөр гаргуулах зохицуулалт, 19.1 хувь нь торгууль, алданги гэх мэт үүргийн гүйцэтгэлийг хангах арга, 17.6 хувь нь хамтран үүрэг гүйцэтгэх, барьцааны зохицуулалтыг сайжруулах шаардлагатай хэмээн хариулжээ. Харин 5.1

хувь нь одоогийн гэрээ, хэлцэлд холбогдох эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, өөрчлөх санал байхгүй, 29.9 хувь нь мэдэхгүй гэсэн байна. Гэхдээ одоогийн эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн хувь маш бага буюу 5.1 хувь байгаа нь эрх зүйн зохицуулалтын өнөөгийн орчны талаар бизнес эрхлэгчид төдийлөн сэтгэл хангалуун бус, эрх зүйн орчинтой холбоотой ямар нэг зүйл болохгүй байгаа гэсэн ерөнхий уур амьсгал бизнес эрхлэгчдийн дунд байгаа болохыг илэрхийлж байна.

6.2. Шинээр зохицуулах шаардлагатай асуудал

Хувиараа бизнес эрхлэгчийн арилжааны бүртгэл, арилжааны нэр

Манай улсын эрх зүйн зохицуулалтын хүрээнд хувиараа бизнес эрхлэгч өөрийн бизнесийн буюу арилжааны нэртэй байх болон бизнес эрхлэгчийн албан ёсны бүртгэл хийгдэх, тайлан тооцоо хөтлөх эрх зүйн орчин бүрдээгүй байна. Энэ нь бизнес эрхлэгчдийн хувьд зайлшгүй зохицуулах шаардлагатай асуудал болохыг энэхүү судалгааны үр дүнгээс харагдаж байна. Өөрөөр хэлбэл, хувиараа бизнес эрхлэгч өөрийн арилжааны нэртэй байх тухайд санал асуулгад оролцогчдын 70-аас дээш хувь шаардлагатай гэж дүгнэснээс гадна бизнес эрхлэгчид тулгамдаж буй асуудал гэсэн 13 бодомж бүхий хариултаас хамгийн эхэнд хувиараа бизнес эрхлэгчийн бүртгэлийн асуудал хөндөгдөж байна.

Үүний гол асуудал нь хувиараа жижиг бизнес эрхэлдэг этгээдийн хувьд санхүүгийн баримт өгөх бололцоогүй, бүртгэгдээгүй санхүүгийн тайлан тооцоо хөтөлдөггүй тул хуулийн этгээдүүд тэдэнтэй бизнесийн харилцаанд орох төдийлөн сонирхолгүй байдаг. Энэ нь томоохон аж ахуйн нэгж, байгууллагуудтай бизнесийн харилцаа тогтоох, бизнесээ өргөжүүлэх, нэмэлт санхүүжилт татах зэрэгт саад болохын хажуугаар хувиараа бизнес эрхлэгчтэй бусад бизнесийн байгууллага хэлцэл хийхээс зайлсхийх, хуурамч баримт бүрдүүлэхэд хүргэж байж болзошгүй байна. Өөрөөр хэлбэл, банк, санхүүгийн байгууллагаас зээл авахад шаардлагатай бизнесийн үйл ажиллагааны орлогыг нотлох санхүүгийн баримт үйлддэггүй, НӨАТ-ын баримт өгдөггүй нөхцөл байдал байсаар байна. Түүнчлэн албан ёсны бизнес эрхлэгчийн бүртгэлгүйгээс аливаа гэнэтийн аюул, гамшигт өртөхөд түүнээс урьдчилан сэргийлэх, хохирлыг нөхөн төлөх бүрэн хэмжээний даатгалын тогтолцоонд хамрагдахгүй, бизнесийн үйл ажиллагаа доголдсон, тасалдсан, зогссон тохиолдолд төрөөс үзүүлж буй хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдаж чадахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Үл өрсөлдөх үүргийн талаар

Аливаа бизнес эрхлэгч нь өөрийн эрхлэн явуулдаг бизнесийн зарим үйл ажиллагаагаа бусад бизнес эрхлэгчид шилжүүлсэн тохиолдолд, тухайн бизнес

эрхлэгчийн эрхийг өөр бизнес эрхлэгч залгамжлан авсан бол өөрийн арилжааны үйл ажиллагааны эрхээ шилжүүлсэн бизнес эрхлэгч нь шилжүүлэн авсан бизнес эрхлэгчтэй өрсөлдөхүйц ижил төрлийн бизнесийн үйл ажиллагаа явуулахгүй байх үүргийг хүлээлгэдэг. Түүнчлэн бизнесийн байгууллагад өндөр албан тушаал хашиж байсан тухайн бизнесийн талаарх бүх мэдээллийг өгч авсан этгээд тухайн бизнесийн байгууллагаас гарч, адил төрлийн арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг бизнесийн байгууллагад ажиллах болсон тохиолдол, эсхүл өрсөлдөх үйл ажиллагааг өөрөө эрхлэх тохиолдолд хэрхэх вэ гэсэн асуудал гарч ирдэг. Манай улсын хувьд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг судлан үзвэл энэ талын зохицуулалт хангалтгүй байгаа учир энэ асуудлыг хэрхэн зохицуулах талаар санал асуулгын судалгаанд оруулсан.

Бизнесийн нууц мэдэх ажилтан өрсөлдөгч аж ахуйн нэгжид ажиллах, адил төрлийн бизнес эрхлэхийг тодорхой хугацаанд хуулиар хязгаарлах, хориглох шаардлагатай гэж судалгаанд оролцогчдын олонхи нь буюу 40.7 хувь нь үзсэн бол шаардлагагүй гэж 30.9 хувь нь үзсэн байна. Үүнд “шаардлагатай” гэж хариулсан бизнес эрхлэгчдийг албан тушаалын ангиллаар авч үзвэл, тухайн бизнесийн үйл ажиллагааны өмчлөгч 10.2 хувь, гэрээгээр ажиллаж байгаа гүйцэтгэх удирдлага, захирал болон бусад албан тушаалтан 89.8 хувь нь байна. Харин “шаардлагагүй” гэж хариулсанаас өмчлөгч 8.3 хувь, гэрээгээр ажиллаж байгаа гүйцэтгэх удирдлага, захирал болон бусад албан тушаалтан 91.7 хувь нь байна.

Мөн эрхэлж байгаа бизнесээ бүхэлд нь худалдсан эсхүл шилжүүлсэн этгээд адил төрлийн бизнес эрхлэхийг хязгаарлах, хориглох хэрэгцээ шаардлага байгаа эсэхэд судалгаанд оролцогчдын 40.6 хувь нь “шаардлагатай” гэж, 32.9 хувь нь “шаардлагагүй” гэж үзсэн байна. Эндээс авч үзвэл, “бизнесийн нууц”-тай холбоотой болон бизнесээ худалдсан этгээд адил төрлийн бизнес эрхлэхийг хязгаарласан харилцааг нарийвчлан тодорхойлж хуульчлах нь зүйтэй байна.

Хэлцлийн зардлын хуваарилалын талаар

Гэрээ байгуулах болон гэрээний үүргийн гүйцэтгэлд гарах зардлыг хэн хариуцах нь чухал ач холбогдолтой юм. Гэвч гэрээ байгуулах зардлын талаар Иргэний хуульд тодорхой зохицуулалт тусгагдаагүй болно. Иймд хуульд гэрээний зардлыг хэрхэн хувиарлах талаар талууд тохиролцож болох зохицуулалт бий болгох нь маргаанаас урьдчилан сэргийлэх, мөн бизнес эрхлэгчийн ашгийн төлөөх үйл ажиллагааг дэмжих, эрх зүйн харилцааг илүү тодорхой болгох ач холбогдолтой. Тиймээс бизнес эрхлэгчдийн дунд хэлцлийн зардлын хуваарилалттай холбоотой судалгаанд оролцогчид хэрхэн дүгнэсэн талаар авч үзье. Судалгаанд оролцогчдын 50 орчим хувь “Гэрээ байгуулахад гарах зардал (нотариатын хураамж, банкны шимтгэл, үнэлгээний зардал

г.м.)-ыг аль тал нь хариуцахыг хуульд тодорхой зохицуулах шаардлагатай, тодорхой байсан нь зүйтэй” гэж, 23.9 хувь нь зарим тохиолдолд шаардлагатай гэж үзсэн (Хүснэгт 6). Өөрөөр хэлбэл, гэрээ байгуулахтай холбоотой гардаг зардлыг талууд тусгайлан тохиролцоогүй бол хуульд заасан зарчим, эсхүл аргын хүрээнд шийдвэрлэхийг дэмжсэн байгаа бол энэ нь гэрээний төрөл, агуулга зэргээс хамаарч ялгамжтай буюу зарим гэрээнд ийм зохицуулалт байхыг дэмжинэ, зарим гэрээнд ийм зохицуулалт байхыг дэмжихгүй гэсэн хариулт гэж тайлж болох юм.

Гэхдээ энд дурдсан үр дүн нь гэрээг бизнес эрхлэгчид байгуулж буй тохиолдолд хуульд зааснаас өөрөөр тохиролцох эрх чөлөөг бүрэн хязгаарлах шаардлагатай эсэхийг авч үзээгүй ба харин стандарт нөхцлийн хувьд гэрээгээр тохиролцох орон зай байх эсэхийг бодолцох шаардлагатай.

6.3. Арилжааны харилцааг тусгайлан зохицуулах хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага

Судалгаанд оролцогчдоос гэрээ, хэлцлийн талуудын бие биедээ итгэх итгэлцлийн төвшингийн талаар тодруулахад дундаас доош үнэлгээ өгчээ. Энэ нь гэрээ, хэлцлийн талуудын итгэлцэл, түүнийг хамгаалах эрх зүйн зохицуулалт дутмаг байгааг илэрхийлж байна.

Иргэний хууль тогтоомжид эрх зүйн харилцаанд оролцогчдын итгэлийг хамгаалах талаар Франчайзын гэрээнд буюу Иргэний хуулийн 336 дугаар зүйлийн 336.3 дах хэсэгт *“Гэрээнд заасан хугацаа дууссан боловч аль нэг талын санаачилгаар талууд харилцан итгэлцэх, хамтран ажиллах зарчмыг удирдлага болгон ажил хэргийн харилцаа дуусгавар болох хүртэл гэрээгээ тодорхой буюу тодорхой бус хугацаагаар тухайн буюу шинэчилсэн нөхцөлөөр сунгаж болно.”* гэж зааснаас өөр энэ талаарх зохицуулалт үгүй байна.

Харин нийтийн эрх зүйд хамаарах Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.8-д захиргааны үйл ажиллагаанд *“хууль ёсны итгэлийг хамгаалах тусгай зарчим”*-ыг хуульчилсан байна. Энэ нь захиргааны үйл ажиллагаанд иргэн, хуулийн этгээд итгэж, ажил хэргээ төлөвлөх, хөрөнгө зардал гаргахад үл эргэлзэх нөхцөл байдлыг бий болгохын зэрэгцээ бизнесийн өсөлтийг дэмжих нэг гол хөшүүрэг болсоо байна.

Иймд Иргэний хууль тогтоомжид гэрээ, хэлцэлд оролцогчдын “итгэлийг хамгаалах зарчим”, үүнийг дэмжсэн зохицуулалтыг бий болгох хэрэгцээ шаардлага нэн тулгамдаж байгаа болохыг харуулж байна. Түүнчлэн бизнес эрхлэгчид гэрээ, хэлцэл зохих ёсоор биелэгддэггүй, байгуулсанаас хойш өөрчлөх, цуцлах, биелүүлэхгүй байх тохиолдол маш их байдаг гэж хариулсан байна.

Бизнесийн харилцаанд оролцогчдоос “итгэлцэл”, “гэрээ, хэлцэл заавал биелэгддэг байх”, “гэрээ, хэлцлийн түргэн шуурхай, баталгаат байдал”-ыг хэрхэн сайжруулах талаар асуухад:

- Хууль тогтоомжийн зохицуулалтаас үүдэлтэй зайлшгүй гарахад хүргэдэг мөнгөн болон бусад зардлыг бууруулах зохицуулалт шаардлагатай;
- Гэрээ, хэлцлийг түргэн шуурхай хийх боломжийг олгосон зохицуулалтыг бий болгох;
- Бизнес эрхлэгчдийн итгэлцлийг хамгаалах зохицуулалт шаардлагатай;
- Бизнес эрхлэгчдийн ашгийн төлөөх зорилгыг хамгаалах зохицуулалт шаардлагатай;
- Бизнес эрхлэгчид гэрээний агуулгаа чөлөөтэй тодорхойлох, түүнийг нь шүүх болон бусад этгээд хүлээн зөвшөөрөх зохицуулалт дутагдалтай байгаа талаар хариулсан байна.

Нэгтгэн хэлбэл, бизнесийн үйл ажиллагааны харилцан итгэлцлийг хамгаалсан, бизнес эрхлэгчдийн хооронд байгуулагдаж буй гэрээ, хэлцлийн баталгаат, түргэн шуурхай байдлыг хангахуйц, бодит үр дүнд хүргэх эрх зүйн зохицуулалтыг бий болгосон тухайлсан эрх зүйн орчин зайлшгүй шаардлагатай болжээ.

ДОЛОО. ДҮГНЭЛТ, САНАЛ

7.1. Дүгнэлт

Энэхүү судалгаагаар Монгол Улс дахь бизнес эрхлэгчдийн дунд бизнесийн гэрээ, хэлцлийг зохицуулж буй эрх зүйн зохицуулалт оновчтой, үр дүнтэй эсэх, түүнчлэн зөвхөн бизнес эрхлэгчдийн харилцааны онцлогийг зохицуулсан бие даасан тусгай зохицуулалт бүхий хууль шаардлагатай юу үгүй юу гэдгийг санал асуулгын болон ярилцлагын аргаар судалсан болно. Судалгааны нарийвчилсан дүгнэлтүүдийг судалгааны тайлангийн 3 болон 4 дүгээр хэсгүүдэд дэлгэрүүлэн танилцуулсан ба дахин давтахгүйгээр ерөнхий гол дүгнэлтүүдийг танилцуулж байна.

1. Бизнес (арилжаа)-ийн үйл ажиллагааны олон чиглэлүүд нь тус бүртээ өөр өөрийн онцлогтой байхын зэрэгцээ тулгамдаж буй асуудлууд нь ч тодорхой нийтлэг болон ялгаатай талуудтай байна. Гэвч бизнес эрхлэх буюу ашиг олох зорилго гэдэг ерөнхий шинжээр нь авч үзвэл тэдэнд нийтлэг байдлаар тулгамддаг адил төсөөтэй асуудлууд олон байдаг.

2. Энэ судалгааны хүрээнд Монгол Улсад бизнес эрхлэх итгэлийн төвшин ямар байгаа, тэрхүү итгэлийг одоогийн эрх зүйн орчин хангалттай хамгаалж, дэмжиж чадаж байгаа эсэхийг судалсан бөгөөд Монгол Улсад бизнес эрхлэхэд бизнес эрхлэгчид бие биедээ итгэх итгэлийн төвшин хангалттай хэмжээнд биш байгаа гэсэн дүгнэлтийг судалгааны үндсэн дээр хийж болохуйц байна. Энд дурдсан итгэлийг бий болгох, хамгаалах нь зөвхөн эрх зүйн асуудал дангаар биш хэдий ч судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн хариултаас үзвэл эрх зүйн одоогийн орчин хангалттай бус, эрх зүйн тодорхойгүй байдал (эрх зүйн эрсдэл) давамгайлж байна.

3. Үүнийг задлан авч үзвэл дараахь 3 дэд асуудлын хүрээнд бизнес эрхлэгчдийн олонх санал нэгтэйд байна гэж үзэж дүгнэлт хийлээ.

Нэгдүгээрт, одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй эрх зүйн орчны зарим зохицуулалтыг өөрчлөх, зохицуулалтыг тодорхой болгох шаардлага байна.

Хоёрдугаарт, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг Монгол Улсад зохицуулалтгүй орхисон, бизнес эрхлэгчдийн өмнө тулгамдсан асуудлыг зохицуулж, хариу өгч чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, эрх зүйн хийдэл байна.

Гуравдугаарт, бизнес эрхлэгчдийн онцлогт нийцсэн ялгамжтай эрх зүйн орчин (жишээлбэл, бие даасан Арилжааны хууль) бий болоогүй байна. Бизнес эрхлэгчийн онцлогийг харгалзсан судалгаанд дурдсан зарим эрх зүйн зохицуулалтын хувилбарыг дэмжих хандлагатай байна.

4. Энэхүү судалгааг нэгтгэн дүгнэвэл, дээр дурдсан олон асуудлуудыг нэг мөр шийдвэрлэх шаардлагатай байгааг харуулахын сацуу, судалгаанд оролцогчдын олонх нь бизнес эрхлэгчдийг тусгайлан зохицуулсан бие даасан хуультай болох шаардлагатай гэж үзсэн нь манай улсад Иргэний хуулиас тусдаа Арилжааны шинжтэй харилцааг зохицуулсан бусад орнуудад өргөн хэрэглэгддэг

Арилжааны хууль (Commercial Code) тай болох шаардлага зүй ёсоор бий болсон гэж дүгнэж байна.

5. Эцэст нь бизнес эрхлэгчдэд одоогийн эрх зүйн зохицуулалт болон арилжааны эрх зүйн суурь зарчмын талаар цэгцтэй, зөв ойлголт өгөх зайлшгүй шаардлагатай байгаа нь санал асуулгын хуудасны мэдэхгүй гэсэн хариултыг олноор бөглөж байгаагаас харагдаж байгааг анхаарах нь зүйтэй байна.

7.2. Санал

Санал асуулгын судалгаа болон ярилцлагын хүрээнд хийгдсэн энэхүү судалгааны үр дүнд үндэслэн Монгол Улсын одоогийн бизнесийн эрх зүйн орчинд Иргэний хуулиас тусдаа Арилжааны бие даасан хууль батлах шаардлагатай гэж зөвлөж байна. Ингэхдээ дараах гол асуудлуудыг тусгах нь зүйтэй байна. Үүнд:

- Хувиараа бизнес эрхлэгчийн бүртгэл, нэрийн асуудал;
- Бизнесийн байгууллагын удирдах албан тушаалд ажиллаж байсан эсхүл тухайн бизнесийн нууцтай холбоотой мэдээллийг мэдэж буй этгээдийн өрсөлдөхгүй байх үүргийн зохицуулалт;
- Бизнесээ худалдсан, шилжүүлсэн этгээд тодорхой хугацаа, нутаг дэвсгэрийн хүрээнд бизнесийг шилжүүлэн авсан этгээдтэй өрсөлдөхгүй байх;
- Бизнес эрхлэгчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх ба хэлцэл хийсний дараа төлөөллийн улмаас хэлцлийн хүчин төгөлдөр байдалд шууд нөлөөлдөг асуудал
- Гэрээ хэлцэл байгуулах эрхийг хэд хэдэн этгээдэд олгох тухай асуудал;
- Бизнесийн харилцаанд нэгэнт тогтож бий болсон зөв практикийг хүлээн зөвшөөрдөг байх тухай. Өөрөөр хэлбэл хэлцэл хийхэд хялбар байх, зардал багатай байх тухай асуудал;
- Талууд тохиролцоогүй байсан ч үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй бол хуульд заасан хүү, торгууль шаардах эрхтэй байх;
- Үл маргах журмаар үүрэг гүйцэтгэхээр тохиролцсон бол шүүхэд хандахгүйгээр үүргийн гүйцэтгэлийг хангуулдаг байх;
- Гэрээ, хэлцэлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, итгэлийг хамгаалах зарчмыг бий болгох зэрэг болно.

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

1. Хавсралт 1. Бизнесийн эрх зүйн орчны талаарх санал асуулга